

**МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ҮНДЭСНИЙ АНХДУГААР
ИЛТГЭЛД НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ ЭРХИЙН ЗӨВЛӨЛ
2010 ОНД ХЭЛЭЛЦЭЖ ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ДУНД
ХУГАЦААНЫ САЙН ДУРЫН ИЛТГЭЛ**

Зөвлөмж	Хариуцах яам, байгууллага	Хэрэгжилтийн байдал
84.1. Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай олон улсын конвенцийг аль болох ойрын хугацаанд соёрхон батлах (Франц Улс)	ГХЯ, ХЗЯ	Хэрэгжилтийн шатанд. Конвенцид Монгол Улс 2008 оны 2 дугаар сарын 6-ны өдөр гарын үсэг зурсан. Соёрхон батлах чиглэлээр ажиллаж байна.
84.2. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцийн нэмэлт протоколыг соёрхон батлах боломжийг нааштайгаар авч үзэх (Мексик Улс)	ХЗЯ	Хэрэгжилтийн шатанд. Нэмэлт протоколд Монгол Улс 2013 оны 9 дүгээр сарын 24-ний өдөр гарын үсэг зурсан. Соёрхон батлах чиглэлээр ажиллаж байна.
84.3. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцийн нэмэлт протоколыг соёрхон батлах, хууль хяналтын ажилтнуудын үйл ажиллагаанд хяналт тавих үр дүнтэй механизмыг нэвтрүүлэх (Шинэ Зеланд Улс)	ХЗЯ	Хэрэгжилтийн шатанд. Соёрхон батлахдаа дотоодын хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар дотоодын хууль тогтоомжийг нэмэлт протоколд нийцүүлж, холбогдох механизмыг бүрдүүлэхээр ажиллаж байна. Улсын Их Хурлаас 2013 оны 7 сарын 5-ны өдөр Цагдаагийн албаны тухай хуулийг баталсан. Тус хуулийн 40 дүгээр зүйлийн 40.5 дахь хэсэгт “Хүний эрхийн Үндэсний Комисс бүрэн эрхийнхээ хүрээнд цагдаагийн алба, алба хаагчийн үйл ажиллагаанд Монгол Улсын Үндсэн хууль, холбогдох хууль тогтоомж, олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөөний талаарх заалтын хэрэгжилтэд хяналт тавина.” гэж заасан. Тиймээс цагдаагийн алба хаагчийн үйл ажиллагаанд хараат бус үндэсний механизм хяналт тавих болсон
84.4. Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн нэмэлт протокол, Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай олон улсын конвенцийг тус тус соёрхон батлах, Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн 22 дугаар зүйлийн дагуу мэдэгдэл гаргах (Испани Улс)	ХЗЯ	Хэрэгжилтийн шатанд. 84.1, 84.2-г харна уу. Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн 22 дугаар зүйлийн дагуу мэдэгдэл гаргах асуудлыг ХЗЯ судалж байна.
84.5. Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын нэмэлт протоколд нэгдэн орох (Аргентин Улс)	ГХЯ	Хэрэгжсэн. Монгол Улс 2009 оны 12 дугаар сарын 23-нд гарын үсэг зурж, 2010 оны 4 дүгээр сарын 23-нд соёрхон баталж, 2010 оны 7 дугаар сарын 1-нд батламж жуух бичгээ хадгалуулсан. Протокол манай улсын хувьд 2013 оны 5 дугаар сарын 5-ны өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж байна.
84.6. Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай олон улсын конвенцид нэгдэн орох (Аргентин Улс)	ГХЯ, ХЗЯ	Хэрэгжилтийн шатанд. 84.1-г харна уу.
84.7. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын нэмэлт II Протоколыг соёрхон батлах (Бразил Улс, Испани Улс)	ГХЯ	Хэрэгжсэн. Монгол Улс Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пактын Цаазаар авах ялыг халах тухай II протоколыг 2012 оны 1 дүгээр сарын 5-нд соёрхон баталж, 2012 оны 3 дугаар сарын 13-нд батламж жуух бичгээ хадгалуулсан. Протокол Монгол Улсын хувьд 2012 оны 6 дугаар сарын 13-ны өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж байна.
84.8. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын цаазаар авах ялыг устгахад чиглэсэн нэмэлт II протоколд гарын үсэг зурж, түүнийг соёрхон батлах (Швед Улс, Португал Улс)	ГХЯ	Хэрэгжсэн. 84.7-г харна уу.
84.9. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын цаазаар авах ялыг устгахад чиглэсэн нэмэлт II протокол зэрэг холбогдох олон улсын	ХЗЯ, ГХЯ	Зарим хэсэг хэрэгжсэн. 84.7-г харна уу.

баримт бичгүүдийг соёрхон батлах, Монгол Улсын эрх зүйн тогтолцооноос цаазаар авах ялыг халахад шаардлагатай алхмуудыг авч хэрэгжүүлэх (Австрали Улс)		Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд шинэчлэн боловсруулж буй Гэмт хэргийн тухай хуулийн төсөлд цаазаар авах ялыг хасахаар тусгасан.
84.10. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын цаазаар авах ялыг устгахад чиглэсэн нэмэлт II протоколыг соёрхон батлах, хууль зүйн практикийг түүнтэй уялдуулах (Канад Улс)	ХЗЯ, ГХЯ	Зарим хэсэг хэрэгжсэн. 84.9-г харна уу.
84.11. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын нэмэлт II протоколыг соёрхон батлах, цаазаар авах ялыг бүрмөсөн устгах үүднээс Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах (Словак Улс)	ХЗЯ, ГХЯ	Зарим хэсэг хэрэгжсэн. 84.9-г харна уу.
84.12. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын нэмэлт II протоколыг соёрхон батлах, улмаар үндэсний хууль тогтоомж, ялангуяа Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах (Итали Улс)	ХЗЯ, ГХЯ	Зарим хэсэг хэрэгжсэн. 84.9-г харна уу.
84.13. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын нэмэлт II протоколд даруй нэгдэн орох (Швейцари Улс)	ГХЯ	Хэрэгжсэн. 84.7-г харна уу.
84.14. Үндэсний хууль тогтоомжийг олон улсын стандартад уялдуулах, олон улсын стандартыг илүү үр дүнтэй хэрэглэх үүднээс шүүгчид болон хууль хяналтын ажилтнуудад сургалт түлхүү явуулах (Малайз Улс)	ХЗЯ, УПЕГ	Зарим хэсэг хэрэгжсэн. ХЗЯ-ны харьяа ХЗҮХ-гээс “Үндсэн хууль ба олон улсын гэрээний харилцан хамаарал”, “Олон улсын гэрээ ба Монгол улсын хуулиудын уялдаа холбоо”, “Олон улсын гэрээг шүүхэд хэрэглэх нь” зэрэг сэдвээр шүүгч, прокурор, өмгөөлөгч, нотариатч, хуульч нарт зориулсан хууль зүйн үргэлжилсэн сургалтын хүрээнд хөтөлбөр боловсруулан зохион байгуулсан сургалтад 2011,2012,2013 онд нийт 500 орчим шүүгч, прокурор хамрагджээ. ХСИС-ийн сургалтын хөтөлбөрт дээрхсэдвүүдийг тусгасан. УПЕГ-аас Олон Улсын эрх зүйн хэм хэмжээ, стандартыг үр дүнтэй хэрэглэх зорилгоор АНУ, Канад, ХБНГУ-аас мэргэжилтэн урьж бүсчилсэн сургалтыг нийт прокурорыг хамруулан зохион байгуулаад байна.
84.15. Хүүхдийн эрхийн конвенцтой дотоодын хууль тогтоомжийг уялдуулах чиглэлээр үргэлжлүүлэн ажиллах, бие махбодийн шийтгэлийн бүх хэлбэрээс урьдчилан сэргийлэх, ийм шийтгэлийг устгах, 18 нас хүрээгүй хүүхдээр аюултай ажил хийлгэхээс сэргийлэх үр дүнтэй арга хэмжээг авч хэрэгжүүлэх (Итали Улс)	ХЯ, ХАХНХЯ	Зарим хэсэг хэрэгжсэн. -Хүүхдийн эрхийг хамгаалахад чиглэсэн Монгол Улсын хууль тогтоомж, эрх зүйн орчин, Хүүхэд, өсвөр үеийн асуудлаарх үндэсний нийт төсөл, хөтөлбөрийн үнэлгээг 2012-2013 онд хийлгэсэн. - Гэмт хэргийн тухай хуулийн төсөлд хүүхдийн хөдөлмөрийг хориглох зохицуулалт тусгасан. -Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийг шинэчлэн найруулж, Хүүхэд хамгааллын тухай шинэ хуулийн төслийг боловсруулж байна. - Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд үрчлэлийн эрх зүйн зохицуулалтыг холбогдох гэрээ конвенцид нийцүүлэн тусгалаа. -Хүүхдийн асрамж, халамжийн төвийн үлгэрчилсэн дүрэм, үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох журмыг шинэчлэн батлуулан хэрэгжүүлж байна. -Хүүхдийн хөдөлмөрийнтэвчишгүй хэлбэрийг устгах үндэсний хөтөлбөрийг 2011 онд батлан хэрэгжүүлж байна. -Хүүхэд ажиллахыг хориглосон ажлын байрны жагсаалтыг 2008 оноос батлан мөрдөж байна. Мөн Хүүхдийн хөдөлмөрийн асуудлаар холбогдох хуульд өөрчлөлт оруулахаар ажиллаж байна. -Үндэсний морин уралдааны морь унаач хүүхдийн хамгаалалтын хувцас, морины хэрэгсэлд тавих шаардлага MNS6264:2011 стандартыг батлуулж, 2012 оны 2 дугаар сарын 1-нээс эхлэн мөрдөж эхлээд байна.

		-Хөдөлмөрийн тухай хуулийншинэчилсэн найруулгын төсөлд хүүхдийн хөдөлмөр эрхлэх насыг ОУХБ-ын 138, 123 дугаар конвенцид нийцүүлж зохицуулалтыг тусгасан.
84.16. Хүний эрх, эрх чөлөөг хамгаалахад чухал ач холбогдол бүхий хууль, эрх зүйн акт, механизмыг баталж нэвтрүүлэх, ялангуяа, дараах салбарт: хохирогч, гэрчийг хамгаалах; хүний эрхийг хамгаалан тэмцэгчдийг хамгаалах; шийдвэр гаргах үйл явцад оролцох иргэний эрхийг хангах; жендэрт суурилсан хүчирхийлэл; хэвлэн нийтлэгчдийн бие даасан байдал; УИХ-ын гишүүдийн хариуцлага; нийтийн ашиг сонирхол бүхий хэрэг, маргаанд иргэний нийгэм оролцох эрх (Унгар Улс)	ХЗЯ, ХАХНХЯ, ЖҮХ	Зарим хэсэг хэрэгжсэн. - Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль 2013 оны 7 дугаар сарын 5-нд батлагдсан. Тус хуулийн хэрэгжилтийг хангахад шаардлагатай дагалдах дүрэм, журмыг боловсруулж батласан. - Хүний эрхийг хамгаалан тэмцэгчдийг хамгаалах талаар 84.35-ыг харна уу. - Жендэрт суурилсан хүчирхийллийн эсрэг үйл ажиллагааны талаар 84.56, 84.74-ыг харна уу. - Шийдвэр гаргах үйл явцад оролцох иргэний эрхийг хангах талаар нарийвчилсан зохицуулалтыг Хууль боловсруулах журмын тухай хууль, Захиргааны ерөнхий хуульд тусгаад байна. - Нийтийн ашиг сонирхол бүхий хэрэг, маргаанд иргэний нийгэм оролцох эрхийн талаар 2012 онд Ерөнхийлөгчийн санаачилгаар олон улсын хурал зохион байгуулсан ба Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нийтийн ашиг сонирхлын өмнөөс иргэний нийгмийн байгууллагууд төлөөлөн оролцох зохицуулалтыг тусгаж өөрчлөхөөр ажлын хэсэг байгуулан ажиллаж байна. Засгийн газрын мөрийн хөтөлбөрт уг асуудлыг тусгасан болно.
84.17. Бэлгийн чиг хандлага, жендэрийн байдлаар алагчилахыг илэрхий хориглосон, алагчилах явдлын эсрэг өргөн хүрээтэй хууль тогтоомж батлах (Канад Улс)	ХЗЯ, ХАХНХЯ	Хэрэгжсэн. 2011 оны 2 дугаар сарын 2-ны өдөр батлагдсан Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хуульд жендэрийн ялгаварлан гадуурхалтыг хориглосон. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжилтийг эрчимжүүлэхээр Засгийн газрын дунд хугацааны стратегийг 2013 оны Засгийн газрын 34-р тогтоолоор баталсан. Шинээр боловсруулж буй Гэмт хэргийн тухай хуулийн төсөлд “ялгаварлан гадуурхах”-ыг гэмт хэрэг хэмээн шинээр томъёолон оруулсан. Шинээр боловсруулж буй Хөдөлмөрийн тухай хуульд ялгаварлан гадуурхалтын шууд болон шууд бус хэлбэрийг хориглохоор тусгасан.
84.18. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцийн дагуу бие махбодийн шийтгэлийн бүх хэлбэрээс урьдчилан сэргийлэх, түүнийг устгах хууль тогтоомжийг батлах (Бразил Улс)	ХЗЯ	Хэрэгжилтийн шатанд Гэмт хэргийн тухай хуулийн төсөлд “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг Конвенц”-д нийцүүлж, гадаадын иргэн харъяалалгүй хүнийг тухайн улсын хуулиар эрүүдэн шүүгдэж болзошгүй тохиолдолд гэмт хэрэгт шалгуулах, ял эдлүүлэхээр шилжүүлэн өгөхгүй байхаар зохицуулсан. Түүнчлэн уг хуулийн төсөлд “эрүүдэн шүүх” гэмт хэргийн бүрэлдэхүүнийг шинээр тусгаж, бусад гэмт хэргийн бүрэлдэхүүнд “эрүүдэн шүүх” нөхцлийг хүндрүүлэх бүрэлдэхүүн байх зохицуулалтыг оруулаад байна.
84.19. Хүний эрх зөрчих явдлыг хуулийн хариуцлагаас гадуур үлдээхгүйн үүднээс Эрүүгийн хуулийн 44.1 дэх хэсгийг хасах буюу өөрчлөх, мөн эрүү шүүлтийг Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцид нийцүүлэн гэмт хэргээр тодорхойлох чиглэлээр Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах (Их Британи Улс)	ХЗЯ	Хэрэгжилтийн шатанд. Анхдугаар илтгэл хэлэлцүүлэх үед энэ зөвлөмж хэрэгжиж байгааг мэдэгдсэн. Эрх зүйн шинэчлэлийн хүрээнд боловсруулж Гэмт хэргийн тухай хуулийн төсөлд Эрүүдэн шүүх гэдгийг тусдаа гэмт хэрэг болгон дараах байдлаар томъёолж оруулсан. “Хууль сахиулагч өөрөө, эсхүл бусдыг хатгаж, эсхүл бусдад зөвшөөрөл олгож, эсхүл бусад байдлаар зөвшөөрч буйгаа илэрхийлж хүнээс тайлбар, мэдүүлэг авах, хэрэг хүлээлгэх, ял, шийтгэл оногдуулах зорилгоор, эсхүл ял, шийтгэл эдэлж байгаатай нь холбогдуулан өөрт нь эсхүл бусад хүний биемахбодь, сэтгэл санааг хүчтэй шаналган зовоосон бол долоон сая төгрөгөөс гучин зургаан сая төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. Эрүүгийн хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсгийг хасах, өөрчлөх талаар тайлагнаагүй байна. Гэмт хэргийн тухай хуулийн төслийн 4.6 дугаар зүйлийн 1-д “...тушаал, даалгаврыг хууль бус болохыг мэдэх боломжгүй эсхүл мэдэлгүйгээр биелүүлж энэ хуулиар хамгаалагдсан ашиг сонирхолд хохирол учруулсныг гэмт хэрэгт тооцохгүй.” гэж өөрчилсөн.
84.20. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу	ХЗЯ	Хэрэгжилтийн шатанд.

хүний нэр төрийг доромжлон харьцах явдлыг устгах зорилгоор хэрэгжүүлсэн санаачилгуудын хажуугаар үндэсний хууль тогтоомжийг Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцид, ялангуяа эрүү шүүлт тулгах гэмт хэргийн тодорхойлолтыг уялдуулан нийцүүлэх (Мексик Улс)		Анхдугаар илтгэл хэлэлцүүлэх үед энэ зөвлөмж хэрэгжиж байгааг мэдэгдсэн. 84.18, 84.19-ийг харна уу.
84.21. Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн заалтуудад нийцүүлэх зорилгоор эрүү шүүлтийн тодорхойлолттой холбоотой дутагдал, мөн эрүү шүүлтийн дүнд олж цуглуулсан нотлох баримтыг аливаа шүүн таслах ажиллагаанд хэрэглэхгүй байх явдлыг хангаагүй Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн дутагдлаа арилгах арга хэмжээ авах (Гана Улс)	ХЗЯ	Хэрэгжилтийн шатанд. Анхдугаар илтгэл хэлэлцүүлэх үед энэ зөвлөмж хэрэгжиж байгааг мэдэгдсэн. 84.19-ийг харна уу. Гэмт хэргийг хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөлд “хууль бусаар цуглуулсан нотлох баримт”-ыг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нотлох баримт гэж үзэхгүй байх заалтыг томъёолсон.
84.22. Эрүү шүүлтийн тодорхойлолтыг Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцид нийцүүлэх зорилгоор холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах, мөн эрүү шүүлтийн дүнд олж цуглуулсан нотлох баримтыг аливаа шүүн таслах ажиллагаанд хэрэглэхгүй байх явдлыг хангах (Нидерланд Улс)	ХЗЯ	Хэрэгжилтийн шатанд. Анхдугаар илтгэл хэлэлцүүлэх үед энэ зөвлөмж хэрэгжиж байгааг мэдэгдсэн. 84.19, 84.21-ийг харна уу.
84.23. Хүн худалдаалах далд бөгөөд гэмт хэргийн шинжтэй үйл ажиллагаанаас хохирогчдыг хамгаалах, тэдэнд туслах зорилгоор хүний наймааны эсрэг хууль батлах (Индонез Улс)	ХЗЯ	Хэрэгжсэн. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль 2012 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр батлагдсан. Энэ хууль батлагдсантай холбогдуулан холбогдох бусад хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан. Тухайлбал Зар сурталчилгааны тухай хууль.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль 2013 оны 7 дугаар сарын 5-ны өдөр батлагдсан.
84.24. Хүний наймааны эсрэг үндэсний хяналтын механизмыг бүрдүүлсэн хүн худалдаалахтай тэмцэх үндэсний тусгай, цогц хууль тогтоомж батлах (Польш Улс)	ХЗЯ	Хэрэгжсэн. 84.23-г харна уу.
84.25. Хүний наймааны хохирогч болон гэрчүүдийг хамгаалах дотоодын хууль тогтоомжийг сайжруулах (Австрали Улс)	ХЗЯ	Хэрэгжсэн. 84.23-г харна уу.
84.26. Хүүхдийн эрхийг хамгаалж, дэмжих үндэсний механизмыг бэхжүүлэх чиглэлээрх үүрэг амлалтаа үргэлжлүүлэн биелүүлэх (Лалын Бүгд Найрамдах Иран Улс)	ХАХНХЯ	Хэрэгжилтийн шатанд. 84.15-ыг харна уу. Монгол Улс Хүүхдийн эрхийн конвенцийн Мэдээлэл хүргүүлэх журмын тухай нэмэлт протоколд 2013 оны 10 дугаар сарын 4-нд гарын үсэг зурсан. Протоколыг соёрхон батлах чиглэлээр ажиллаж байна.
84.27. Шинээр 10 жилийн хугацаатай Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах Үндэсний хөтөлбөрийг батлах талаар хүчин чармайлт гаргах (Алжир Улс)	ХАХНХЯ	Хэрэгжилтийн шатанд. Хүүхэд хамгааллыг бэхжүүлэх стратегийг 2011 онд, Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах үндэсний хөтөлбөрийг 2011 онд, Хүүхдийн хөгжлийн шаталсан хөтөлбөрийг 2013 онд тус тус хэрэгжүүлж байна. Засгийн газраас хүүхдийн хөгжил хамгааллын асуудлыг гэр бүл суурьтай хөгжлийн бодлогод тулгуурлан авч үзэж Хүн амын хөгжлийн цогц бодлогыг 2014-2024 он хүртэлх хугацаанд хэрэгжүүлэхээр боловсруулаад байна. 2014 оныг "Гэр бүлийн хөгжлийг дэмжих" жил болгон зарлаж Гэр бүлийн тогтвортой байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг боловсруулж эхлээд байна.
84.28. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газраас баталсан 2008-2012 оны Үйл ажиллагааны төлөвлөгөөг амжилттай хэрэгжүүлэх (ОХУ)	ХАХНХЯ	Хэрэгжсэн. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих Үндэсний хөтөлбөр нь 2012 онд хэрэгжиж дуусан бөгөөд тус хөтөлбөрийн үндсэн 6 зорилтын хүрээнд хийгдсэн 68 арга хэмжээ, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оролцоог дэмжих дэд хөтөлбөрийн 4 зорилт, 4 дэд зорилтын хүрээнд хийгдсэн 44 арга хэмжээний хэрэгжилтэнд Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам болон

		НҮБ-ын Боловсрол, соёл, шинжлэх ухааны байгууллагатай байгуулсан гэрээний хэрэгжилтийг хангах зорилгоор Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2013 оны 11 дүгээр сарын 6-ны өдрийн А/281 тоот тушаалаар хяналт шинжилгээ хийх, үр дүнг тодорхойлох чанарын судалгаа хийх ажлын хэсэг ажиллаа.
84.29. Үндэсний Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан хүний эрхийн бүх санаачилгыг үр дүнтэйгээр хэрэгжүүлж, хянах (Индонез Улс)	ЗГ,ХЗЯ	Хэрэгжилтийн шатанд. Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр нь 2003 онд батлагдсан бөгөөд ЗГ-аас хоёр удаа 2 жилийн төлөвлөгөө батлан, хэрэгжүүлж,ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлсэн. 2012 оны 2 дугаар сарын 29-ний өдөр явцын хяналт шинжилгээний тайланг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн УИХ-д өргөн мэдүүлсэн.2013 оны 6 сарын 12-нд Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн хорооны гишүүдэд Үндэсний хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт оруулах талаар санал авахаар явуулаад байна.
84.30. Ядуурлыг (ялангуяа хотын зах хэсэг болон хөдөө, орон нутагт) арилгах стратегийг хэрэгжүүлэхэд хүчин чармайлт гаргах (Индонез Улс)	ХАХНХЯ	Хэрэгжилтийн шатанд. Өрхийн амьжиргааны түвшин тогтоох аргачлалыг Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.2-т заасны дагуу ҮСХ болон Нийгмийн хамгааллын сайд хамтарсан тушаалаар баталсан. Энэ аргачлалыг Дэлхийн банкны хамтын ажиллагааны хүрээнд онлайн хэлбэрт шилжүүлэхээр ажиллаж байна. Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт хүргэх” зорилтыг хангах, “Улсын хэмжээний судалгаа хийх тухай” Засгийн газрын 2013 оны 269 дүгээр тогтоолын дагуу өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох “Орлогыг орлуулан тооцох аргачлал”-аар өрхийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх улсын хэмжээний судалгаа хийж, түүнд тулгуурлан ядуурлын эсрэг тодорхой ажлуудыг хийж гүйцэтгэж байна. Засгийн газраас МХЗ-уудын хэрэгжилтийг 2 жил тутам дүгнэн, УИХ-д тайлагнаж ирсэн бөгөөд МХЗ-уудын 2011-2012 оны хэрэгжилтийн Үндэсний 5 дахь илтгэлийг боловсруулж, НББСШУ-ны Байнгын хорооны МХЗ-ууд болон ядуурлыг бууруулах асуудлын дэд хорооны 2013 оны 11 дүгээр сарын 20-ны хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжүүлэв. Үндэсний 5 дахь илтгэлийн гол онцлог нь МХЗ-уудын хэрэгжилтийн 1990 оноос хойш чиг хандлагыг авч үзэж, Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, нөлөөлсөн хүчин зүйл, хүндрэл бэрхшээлд үнэлгээ, дүгнэлт хийсэн. Тайланд Монгол Улс уул уурхайн томоохон төслүүдийг хэрэгжүүлж, дэд бүтэц, бүтээн байгуулалтын ажлуудыг өрнүүлж, бодит салбарын хөгжлийг хөхиүлэн дэмжсэнээр эдийн засгийн өсөлтийн хурдацыг эрчимжүүлж, улмаар бүтээн байгуулалтын ажлын үр дүнд ажлын байр олноор бий болж, МХЗ-уудын хамгийн гол үзүүлэлт болох ядуурал буурч, 27.4 хувьд хувьд хүрсэнийг тэмдэглэсэн. Тус тайлан, хэлэлцүүлгийн үр дүнг НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын дэргэдэх Дээд хэмжээний зөвлөл болон Тогтвортой хөгжлийн зорилтуудын талаарх нээлттэй ажлын хэсэгт 2013 оны 05 дугаар сарын 15-нд хүргүүллээ.
84.31. Үндэсний нөхцөл байдлыг харгалзан, ялангуяа эдийн засгийн хөгжил, ядуурлыг арилгах, нийгмийн эмзэг бүлгийн эрхийг хамгаалахыг нэн тэргүүнд анхааран хүний эрхийн төлөө үйл хэргээүргэлжлүүлэн урагшлуулах (БНХАУ)	ХАХНХЯ, ҮХААЯ	Хэрэгжилтийн шатанд. Хүнсний эрхийн бичиг олгох журмыг батлуулж, нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай иргэдэд хүнсний бүтээгдэхүүн худалдан авах эрхийн бичгийг сар бүр олгож байна. Нийгмийн халамжийн туслалцаа дэмжлэг зайлшгүй шаардлагатай 16822 өрхийн 113187 иргэнд хүнсний эрхийн бичиг олгох ажлыг 2013 оны 1 дүгээр сараас эхлэн хэрэгжүүлж байна. Энэхүү үйлчилгээг хүргэх 688 дэлгүүрийг орон нутагт хуулийн дагуу сонгон шалгаруулаад байна. Орон гэргүй тэнэмэл амьдралтай иргэдийг нийгэмшүүлэх чиглэлээр халамжийн тодорхой үйл ажиллагааг тогтмол явуулж байгаа бөгөөд тусгайлсан үйлчилгээний хөтөлбөр боловсруулж байна. 2 аймаг, 6 дүүрэгт 220 орон гэргүй иргэдэд халуун хоол цай өгөх болон түр хоноглуулах үйлчилгээг хуулийн дагуу сонгон

		шалгаруулсан ТББ, ХХК-аар дамжуулан үзүүлээд байна. Улаан загалмай нийгэмлэгтэй хамтарч 263 иргэнд дулаан хувцас тараагаад байна.
84.32. Авлигын гэмт хэргийг Төрийн нууцын тухай хуулийн хүрээнд хамааруулах асуудлыг хязгаарлаж, үйл ажиллагаа, шийдвэрийг илүү ил тод болгох, улмаар холбогдох шийтгэлийг бүрэн хэрэгжүүлэх үүднээс хяналтын байгууллагуудын бие даасан байдлыг хангах, ийм үйл ажиллагаанд нэвтрэх боломжийг эдгээр байгууллагад олгох (Швейцари Улс)	ҮАБЗ-ийн АА АТГ	Хэрэгжсэн. Төрийн албаны ил тод байдлыг хангах, авилга, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор УИХ 2012 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль” баталж мөн оны 5 дугаар сарын 1-нээс дагаж мөрдөж байна. Уг хуулийн дагуу албан тушаалтан ашиг сонирхлын мэдүүлэг гаргаж байгаа бөгөөд энэ нь нийтэд нээлттэй байхаар зохицуулсан. АТГ нь нийтийн албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэсэн байдлын талаар жил бүрийн 3 дугаар сарын 1-ний дотор цахим хуудсаар болон “Төрийн мэдээлэл” сэтгүүлд мэдээлж байна. “Нийтийн албан нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-д оруулсан нэмэлт өөрчлөлтөөр мэдээлэх үүргийг хэрэгжүүлэхэд төр, байгууллага, хувь хүний нууцын хязгаарлалт хамаарахгүй байхаар зохицуулсан.
84.33. Гадаадын иргэдэд хандах хандлага, үзүүлэх үйлчилгээг сайжруулахад түлхүү анхаарах (БНСУ)	ХЗЯ	Зарим хэсэг хэрэгжсэн. Монгол улс дах гадаадын иргэдэд үзүүлэх үйлчилгээг сайжруулахад анхаарал тавьж визний мэдүүлгийг цахимаар илгээх, хилийн боомт дээр виз олгох зэрэг ажлыг хийж байна. ХБНГУ-ын иргэдийг 30 хүртэлх хоногийн хугацаанд визгүй зорчуулах шийдвэрийг 2013 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс, Канад улсын иргэдийг 30 хүртэлх хоногийн хугацаанд визгүй зорчуулах шийдвэрийг 2014 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжүүлж байна. Гэмт хэрэгт холбогдсон гадаадын иргэдийн талаарх мэдээлийг ЦЕГ гадаад харилцааны хэлтэст 24 цагийн дотор хүргүүлж, холбогдох газарт нь уламжилдаг. Мөн ЭБШ хууль заасны дагуу өмгөөлөгч авах, эх хэлээрээ болон мэддэг хэлээрээ мэдүүлэг өгөх, өмгөөлөгч авах, орчуулагч, хэлмэрч авах эрхээр хангадаг. УБ хотод оршин суугаа болон тус улсад зочилж ирсэн гадаадын иргэдийн аюулгүй байдлыг хангах, гэмт халдлагаас хамгаалах, урьчилан сэргийлэх асуудлаар Монгол Улсад суугаа гадаад орны дипломат төлөөлөгчийн газар, Засгийн газар хоорондын олон улсын байгууллагын төлөөлөгч нарыг оролцуулсан уулзалт-ярилцлагыг 2012 онд зохион байгуулсан. Уулзалт-ярилцлагад 24 дипломат төлөөлөгчийн газар, 14 гадаадын байгууллага болон Гадаад харилцааны яамны Консулын газрын төлөөлөгч оролцож саналаа солилцсон байна. Гадаадын иргэд гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд тэдгээрийн эрхийг хамгаалж прокуророос тавих хяналтыг сайжруулах зорилгоор УЕП-ын 2011 оны 32 дугаар тушаалаар баталсан “Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа, түүнд тавих прокурорын хяналтын ажилд ЭБШХ-н заалтыг дагаж мөрдөх аргачилсан зааврын 91 дүгээр зүйлийн 91.1г-д “ Гадаадын иргэдээс үйлдсэн онц хүнд, хүнд гэмт хэргүүдэд УМБГ-с мөрдөн байцаалт явуулж, Нийслэлийн прокурорын газраас хяналт тавьж ажиллах заалт оруулаад байна.
84.34. УИХ болон Засгийн газрын шийдвэр гаргах үйл явцыг ил тод болгох, хууль тогтоомжийг олон нийтээр хэлэлцүүлэх явдлыг хангах бүтэц, зохион байгуулалтыг бий болгох (Их Британи Улс)	ЗГ,ХЗЯ	Хэрэгжилтийн шатанд. Эрх зүйн шинэчлэлийн бодлогын хүрээнд Хууль боловсруулах журмын тухай хууль, Захиргааны ерөнхий хуулийн төслийг боловсруулж байна. Уг хуулийн төсөлд иргэдийн оролцооны талаар дэлгэрэнгүй зохицуулалтыг оруулсан болно.
84.35. Үндэсний ээлжит хэлэлцүүлгээс гаргасан зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхэд иргэний нийгмийн, түүний дотор цөөнхийг төлөөлж буй байгууллагуудын оролцоог хангах (Норвеги Улс)	Бүх яам, байгууллага	Хэрэгжилтийн шатанд. Засгийн газар Хүний эрхийн үндэсний комисс, иргэний нийгэмтэй хамтран “Хүний эрхийн төлөв байдлыг талаарх ээлжит нэгдсэн хэлэлцүүлгийн (UPR) зөвлөмжийн хэрэгжилт, дунд хугацааны тайлантай холбогдуулан мэдээлэл солилцож, зөвлөлдөх нь” сэдвээр 2013 оны 7 дугаар сарын 3-ны өдөр

		уулзалт зохион байгуулсан. Үүний үр дүнд Монгол Улсын нэгдэн орсон хүний эрхийн талаархи олон улсын гэрээний хэрэгжилтийн илтгэлийг бэлтгэн боловсруулж, НҮБ-ын гэрээний хороод, олон улсын бусад байгууллагад хүргүүлэх, Монгол Улсын Хүний эрхийн төлөв байдлын үндэсний илтгэл болон хүний эрхийн талаар НҮБ-аас өгсөн бусад зөвлөмжийн хэрэгжилтийг сайжруулах зорилгоор 2013-2014 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Гадаад харилцааны сайд, Хууль зүйн сайдын хамтарсан тушаалаар 2013 оны 10 дугаар сарын 8-ны өдөр баталсан. Төлөвлөгөөнд төрийн бус байгууллагатай байнга зөвлөлдөж байхаар тусгасан. Мөн UPR-ын дунд хугацааны сайн дурын илтгэл бэлтгэх Ажлын хэсгийг Ерөнхий сайдын захирамжаар байгуулахдаа иргэний нийгмийн саналыг харгалзахыг зөвлөсөний дагуу хамтран ажилласан. Хүний эрхийн төлөв байдлын хоёрдугаар илтгэл бэлтгэхэд иргэний нийгмийн оролцоог сайн хангахад анхаарах болно.
84.36. Энэхүү хэлэлцүүлгийн мөрөөр хэрэгжүүлэх болон Хүний эрхийн Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд дотоодын хүний эрхийн байгууллагуудыг хамруулах (Их Британи Улс)	Бүх яам, байгууллага	Хэрэгжилтийн шатанд. 84.35-г харна уу.
84.37. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах зорилгоор тэдний эрхийг дэмжихийн тулд холбогдох бүх байгууллагыг оролцуулах явдал амин чухал бөгөөд дэд бүтцийн болон сэтгэл зүйн орчинг бүрдүүлэх шаардлагатай (Казахстан Улс)	ХАХНХЯ, ЭМЯ	Зарим хэсэг хэрэгжсэн. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцийг хэрэгжүүлэх 2013-2016 оны арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай Монгол Улсын Засгийн газрын тогтоол батлагдсан. Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогод “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил, хамгааллын бодлого-шинэчлэл” үндэсний чуулганыг 2013 онд холбогдох бүх талуудыг оролцуулан зохион байгууллаа. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. Хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгээс одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн хэрэгжилтийн үр нөлөөг бүлэг тус бүрээр үнэлээд байна. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд эрүүл мэнд, боловсрол, нийгмийн үйлчилгээ үзүүлэх, сэргээн засах, тэдний гэр бүлд зөвлөгөө өгөх, дэмжин туслах хөгжлийн төвүүдийг бүх аймаг дүүрэгт үе шаттайгаар байгуулах ажлыг эхлүүлээд байна.
84.38. Нийгмийн эмзэг бүлгийн, ялангуяа эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх, ажил эрхлэлт, нийгмийн хамгааллын талаар тусгай арга хэмжээ авч хэрэгжүүлэх (Лалын Бүгд Найрамдах Иран Улс)	ХЯ, ХАХНЯ	Хэрэгжилтийн шатанд. Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс 2012 онд баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байрыг нэмэгдүүлэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх зорилгоор 2012 онд хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах хөгжлийн бэрхшээлтэй иргэний бизнес төслийн шалгаруулалтанд улсын хэмжээнд нийт 1256 төсөлд 1 тэрбум 668 сая төгрөгийн санхүүжилт олгож, 1456 хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажлын байртай болсон байна. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн дунд хязгаарлагдмал тендер зарлаж 33 төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжид 759,4 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг олгож, 114 хөгжлийн бэрхшээлтэй иргэн байнгын ажлын байртай болсон байна. 2013 онд “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийг хэрэгжүүлснээр хувиараа болон нөхөрлөл, хоршооны хэлбэрээр аж ахуй эрхлэхийг хүссэн 903 төсөл шалгаруулж 1 тэрбум төгрөгийн санхүүжилт олгож, 1204 байнгын ажлын байр бий болсон. Хөгжлийн бэрхшээлтэй 91 иргэнийг байнгын ажлын шинэ байраар хангасан 26 аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагад 300 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлэв. 2012-2013 онд нийт 3 тэрбум 427,4 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлсэн байна. Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын талаар

		84.46, 84.47, 84.48, 84.50, 84.51-ийг харна уу.
84.39. Гэрээний байгууллагуудад илтгэлээ тогтмол хүргүүлэх ажлыг сайжруулах, ялангуяа 2003 оноос хойш хугацаа хоцорч буй Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын хэрэгжилтийн илтгэлийг хүргүүлэхэд анхаарах (Франц Улс)	ГХЯ, Бусад яамд	Хэрэгжилтийн шатанд. Хугацаа хоцорч буй “Арьс үндсээр алагчилах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц”-ийн хэрэгжилтийн талаархи 19, 20, 21 дүгээр хамтатгасан илтгэлийг 2013 оны 11 дүгээр сард Засгийн газраар хэлэлцүүлсэн. Одоо ХЗЯ орчуулга бэлтгэж байна. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын хэрэгжилтийн илтгэлийг хүргүүлсэн. 2014 онд 4 илтгэл бэлтгэх хуваарийн дагуу илтгэл бэлтгэх ажил эхлээд байна.
84.40. Гэрээний байгууллагад тогтмол хүргүүлэх илтгэлүүдээ эцэслэж, хүргүүлэхэд нэн тэргүүнд анхаарах (Австрали Улс)	Бүх яам	Хэрэгжилтийн шатанд. 84.39-г харна уу.
84.41. Хугацаа хоцорсон илтгэлүүдийг НҮБ-ын гэрээний байгууллагуудад хүргүүлэхэд нэн тэргүүний анхаарал хандуулах (Норвеги Улс)	Бүх яам	Хэрэгжилтийн шатанд. 84.39-г харна уу.
84.42. Хүний эрхийн бүх гэрээний байгууллагуудад тайлангаа тогтмол хүргүүлэх (Словени Улс);	Бүх яам	Хэрэгжилтийн шатанд. 84.39-г харна уу.
84.43. Хүн худалдаалах, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалах асуудлаарх Тусгай илтгэгчийг урих (Шинэ Зеланд Улс)	ХАХНХЯ, ГХЯ	Хэрэгжилтийн шатанд. Монгол Улсын Засгийн газар 2004 онд хүний эрхийн тусгай мандат эзэмшигчдийг бүгдийг урьж буй нээлттэй урилгаа зарлаж, түүнээс хойш энэ байр сууриа нотолж ирсэн. Тусгай илтгэгч нар нээлттэй урилга бүхий орнуудын нөхцөл байдлыг харгалзаж, очих улсаа тодорхойлдог. Манай Засгийн газрын зүгээс тусгайлан дахин урилга өгөх, айлчлуулах талаар Женев дэх БТГ-аараа дамжуулан ажиллах боломжтой.
84.44. Алагчилахын эсрэг хууль тогтоомжийг бэхжүүлж, түүнийг үр дүнтэй хэрэгжүүлэх зэрэг замаар хүний эрхийн соёлыг хангах (Норвеги Улс)	ХЗЯ, ХАХНХЯ	Хэрэгжилтийн шатанд. 84.17-г харна уу.
84.45. Шийдвэр гаргах дээд түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог дэмжихийн зэрэгцээ төрийн болон хувийн салбар дахь алагчилалтай тэмцэх илүү хатуу арга хэмжээг авч хэрэгжүүлэх (АНУ)	ХЗЯ, ЖҮХ	Зарим нь хэрэгжсэн. 84.17-г харна уу. УИХ-ын 2012 оны сонгуулиар 174 эмэгтэй нэр дэвшиж, 11 эмэгтэй сонгогдсон нь өмнөх нөхцөл байдлаас 4 дахин нэмэгдсэн. 2012 онд байгуулагдсан Засгийн газрын танхимын 19 гишүүний 3 нь эмэгтэй сайд, 16 яамны Төрийн нарийн бичгийн даргын 3 нь эмэгтэй, 2 эмэгтэй дэд сайд нар тус тус томилогдон ажиллаж байна. 2011 онд батлагдсан Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 7-р зүйлд эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрхийг хангахаар тусган хэрэгжүүлж байна. Мөн хуулийн 10-р зүйлд төрийн алба болон хувийн хэшилд жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаарх квотуудыг тусган хуульчилсан. Жил бүрийн 2 дугаар сарын 10-ны дотор тайланг авч нэгтгэн Засгийн газарт танилцуулдаг. УИХ-ын сонгуулийн тухай хуульд улс төрийн нам бүр сонгуульд 20-оос доошгүй хувиар эмэгтэй нэр дэвшигч байхаар хуульчилсан. - Хэвлэл мэдээллийн хэрэгслээр охид, эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах, тэдний эсрэг хүчирхийллийг таслан зогсоохын төлөө ухуулга сурталчилгааны үйл ажиллагааг жил бүр холбогдох төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулж байна
84.46. Жендэрийн эрх тэгш байдлын тухай хуулийг баталж, эрх тэгш байдлыг хангах механизмыг бий болгох (Гана Улс)	ЖҮХ, ХҮЭК	Хэрэгжсэн. 84.17-г харна уу. ЖҮХ-г Монгол Улсын Ерөнхий сайд даргалан ажилладаг. Дэд дарга нь МУ-ын Ерөнхий сайдын ахлах зөвлөх ажилладаг. Ажлын албатай. Ажлын алба нь 8 хүний бүрэлдэхүүнтэй. -ЖҮХ нь хууль, дүрэмд зааснаар 25 орон тооны бус гишүүнтэй.

		<p>Гишүүдэд Засгийн газрын гишүүд болон холбогдох төр болон төрийн бус, хувийн хэвшил, хэвлэл мэдээллийн байгууллагын удирдлагууд багтдаг.</p> <p>-Мөн 21 аймаг, 9 дүүрэг, 16 яамдын салбар хороо, зөвлөлийг бүтэцтэй ажиллаж байна. Салбар хороо, зөвлөлийн даргаар тухайн аймаг, нийслэл, дүүргийн засаг дарга нар, яамдын сайд нар ажилладаг.</p> <p>-Бүх салбар хороо, зөвлөлд жендэрийн мэргэжилтнүүд хавсран ажиллаж, үндсэн цалингийн 30 хувьтай тэнцэх цалинг авч ажиллаж байна.</p> <p>- Жендэрийн Үндэсний хорооны чиг үүргийг 2011 онд батлагдсан ЖЭТБХТХ-ийн 18 дугаар зүйлд тусгаж өгсөн.</p> <p>-Засгийн газрын ХЭГ-ын хяналт, шалгалт, үнэлгээний хэлтсээс засаг дарга, сайд нарын ажил, үүргийг дүгнэх шалгуур үзүүлэлтэд жендэрийн эрх тэгш байдлыг хангах хуулийн хэрэгжилтийн талаарх 2 шалгуур үзүүлэлт тусгуулсан.</p> <p>-Төрийн захиргааны төв байгууллага болон нутгийн захиргааны байгууллага жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны явц, үр дүнгийн тухай тайланг Жендэрийн үндэсний хороонд дараа оны 2 дугаар сарын 10-ны дотор хүргүүлдэг. Тайланг нэгтгэн Засгийн газарт танилцуулдаг.</p> <p>-Хүний эрхийн үндэсний комиссоос жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 11-р зүйл буюу хөдөлмөрийн харилцаан дахь жендэрийн тэгш байдлын зүйл заалтын хэрэгжилтэд үнэлгээ хийсэн. УИХ-д тайлагнана.</p> <p>- ЖҮХ нь Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын биелэлтийн тайланг дараа оны 2 дугаар сарын 1-ний дотор Эдийн засгийн хөгжлийн яаманд хүргүүлдэг.</p>
84.47. Эмэгтэйчүүд, охидтой зүй бусаар харьцах, тэднийг алагчилахтай тэмцэх талаар одоогийн эрх зүйн хамгаалалтыг бэхжүүлж, хэрэгжилтийг сайжруулах (АНУ)	ХЗЯ, ХАХНХЯ ЖҮХ	<p>Хэрэгжсэн.</p> <p>Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд ялгаварлан гадуурхалтыг хориглох заалт тусгасан. Охид, эмэгтэйчүүдээс хүний эрхийг зөрчсөн өргөдөл, гомдлыг Хүний эрхийн үндэсний комисс хүлээн авч шийдвэрлэдэг механизм бүрдсэн.</p> <p>2004 онд батлагдсан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг шинэчлэн найруулж бусад холбогдох хуулийн заалттай уялдуулан батлуулсан.</p> <p>Хууль зүйн яам Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан 2014 оны 1-р сард багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна.</p> <p>Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийг 2012 онд баталсан.</p>
84.48. Жендэрийн эрх тэгш байдлын тухай хуулийг шуурхай баталж, Жендэрийн тэгш байдлын Үндэсний хороонд холбогдох эрх хэмжээг олгох, мөн эмэгтэйчүүдийг, ялангуяа хөдөөгийн эмэгтэйчүүд зэрэг нийгмийн эмзэг бүлгийг алагчилах явдлыг арилгах талаар зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэх (Словак Улс)	ЖҮХ, ХЗЯ, ХАХНХЯ	<p>Хэрэгжсэн.</p> <p>84.46-г харна уу.</p> <p>ЖҮХ, түүний ажлын албанд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 18-р зүйлд заасан эрх хэмжээ, хариуцлагыг тодорхойлсон байна. Засгийн газрын 2007 оны 9 дүгээр сарын 225-р тогтоол, Засгийн газрын 2011 оны 11 дүгээр сарын 323-р тогтоолоор тус тус ЖҮХ-ны хариуцах чиг үүргийг мөн тогтоосон.</p> <p>Жил бүр улсын төсөвт урсгал зардлыг тусгадаг бөгөөд анх 2014 оны төсөвт Засгийн газрын дунд хугацааны стратегийг хэрэгжүүлэх мөнгийг төсөвт суулгаж өгсөн.</p> <p>2014 онд ЖҮХ нь эмэгтэйчүүдийн, ялангуяа хөдөөгийн эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавхийг сайжруулах төлөвлөгөө батлуулан ажиллаж байна. Мөн хөгжлийн бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхалтаас ангид байлгах, өөртөө итгэлтэй болгох чиглэлээр ажиллаж байна. Хөдөөгийн охид, эмэгтэйчүүдийн хүний эрх, эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулахаар уул уурхайн томоохон компаниудтай ажиллах Санамж бичиг байгуулан ажиллаж байна.</p>
84.49. Алагчиллын бүх хэлбэрийг, ялангуяа жендэрт суурилсан алагчиллыг устгах цогц стратегийг батлах замаар үл алагчилах зарчмыг баталгаажуулсан хууль тогтоомжийн	ХЗЯ, ЖҮХ	<p>Хэрэгжилтийн шатанд.</p> <p>84.17-г харна уу.</p> <p>Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлтийг эрчимжүүлэхээр Засгийн газрын дунд хугацааны стратегийг 2013 оны Засгийн газрын 34-р тогтоолоор баталсан.</p>

хэрэгжилтийг хангах үр дүнтэй арга хэмжээ авах, үндэсний хууль тогтоомжийг соёрхон баталсан олон улсын баримт бичгүүдтэй уялдуулах чиглэлээр хүчин чармайлтаа бэхжүүлэх (Украин Улс)		
84.50. Эмэгтэйчүүдэд адил тэгш боломж олгоход чиглэсэн бодлого боловсруулах (Нидерланд Улс)	ХАХНХЯ ЖҮХ, ХЯ	Хэрэгжилтийн шатанд. 84.17-г харна уу. Монгол Улсын Хөдөлмөрийн хуулийн 101 дүгээр зүйлд заасны дагуу гаргасан Эмэгтэйчүүдийг ажиллуулахыг хориглосон "Жагсаалт шинэчлэн батлах тухай" Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 1999 оны А/204 тоот тушаалыг 2008 оны Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 107 тоот тушаалаар хүчингүйд тооцсон.
84.51. Ажил эрхлэлтийн салбарт эмэгтэйчүүдийн тэгш эрхийг хангах (Норвеги Улс)	ХЯ ЖҮХ	Хэрэгжилтийн шатанд. 84.17-г харна уу. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 11 дүгээр зүйлд хөдөлмөрийн харилцаан дах тэгш байдлыг зохицуулсан. Энэхүү хуулийн зохицуулалтыг Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад уялдуулан ажлын байрны бэлгийн дарамтлал, эхийн хамгаалал, адил хөдөлмөр буюу адил чанарын ажил эрхэлж байгаа эрэгтэй, эмэгтэй ажилтанд тэгш цалин хөлс олгох тухай шинэ зүйл заалт оруулсан.
84.52. Ижил үнэлгээтэй ажил гүйцэтгэсний төлөө ижил хэмжээний хөлс олгох явдлыг хангах (Норвеги Улс)	ХЯ, ЖҮХ	Хэрэгжилтийн шатанд. 84.17, 84.51-ийг харна уу. Анхдугаар илтгэл хэлэлцүүлэх үед энэ зөвлөмж хэрэгжиж байгааг мэдэгдсэн.
84.53. Эхчүүдийн хамгааллыг бэхжүүлэх (Норвеги Улс)	ЭМЯ	Хэрэгжилтийн шатанд. Эх, хүүхдийн эрүүл мэндийн чиглэлийн сургалт, сурталчилгаа, судалгааны ажилд орон нутгийн шийдвэр гаргагч Засаг дарга, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд хувь нэмэр оруулж, идэвхитэй хамтран ажиллаж байна. Зарим аймагт "Эх, нярайн эрүүл мэндийн сан" байгуулж, сангийн хөрөнгийг дээд шатны эмнэлэгт шилжүүлэн эмчлүүлэх шаардлагатай, нэн ядуу эх, нярайд зарцуулдаг болсон. Алслагдсан нутгийн малчин иргэдэд эмнэлгийн тусламж үзүүлэх "Нүүдлийн амбулатори", "Мэргэжлийн эмч нарын баг"-ийг сумдад ажиллуулж туршсанаар яаралтай дуудлага буурсан байна. Эхчүүдийн нийгмийн хамгааллыг сайжруулахад эрүүл мэндийн байгууллагууд дүүрэг, аймгийн Нийгмийн даатгалын байгууллага, Иргэний бүртгэл мэдээллийн байгууллага, Халамжийн байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Тусламж, үйлчилгээний тэгш бус байдлыг арилгахад чиглэсэн "Дүүрэг бүрт хүрч үйлчилье" стратегийг Баянзүрх, Сүхбаатар дүүрэг, Дорнод, Увс, Ховд, Баян-Өлгий аймагт хэрэгжүүлснээр алслагдсан болон эмзэг бүлгийн эмэгтэйчүүдийг илрүүлэн тусламж үйлчилгээнд хамруулж байна.
84.54. Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийг устгахад хүчин чармайлтаа нэмэгдүүлэх (Норвеги Улс)	ХЗЯ, ХАХНХЯ, ЭМЯ	Хэрэгжилтийн шатанд. - Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд шинэчлэн боловсруулж буй Гэмт хэргийн тухай хуулийн төсөлд шинээр "гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх" бие даасан гэмт хэргийг тусгаж, бусад гэмт хэргийг үйлдэхдээ "гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж" үйлдсэн бол хүндрүүлэхээр тус тус тусгасан байна. Түүнчлэн "бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг"-ийн бүлгийг шинээр тусгасан байна. - Хууль зүйн яам Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан 2014 оны -р сард багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна. - ХАХНХЯ, ЭМЯ, ХЗЯ-тай хамтран Нэг цэгийн үйлчилгээний төвийг Говь-Алтай аймагт нэгдсэн эмнэлэгт, Завхан аймагт цагдаагийн газарт түшиглэсэн "Хүчирхийлэлд өртөгсдөд үйлчилгээ үзүүлэх нэг цэгийн үйлчилгээ"-ний загвар төвийг зохих бэлтгэл нь бүрэн хангагдсан бөгөөд ажиллагааг эхлүүлээд байна.
84.55. Тийм гэмт хэргийн хохирогчдыг	ХЗЯ,	Хэрэгжсэн.

зохих ёсоор хамгаалах, нийгэмшүүлэх явдлыг хангах (Норвеги Улс)	ХАХНХЯ	84.23-ыг харна уу.
84.56. Бэлгийн чиг баримжаагаар алагчилах, хүчирхийлэхийн бүх хэлбэрийг нээлттэй буруушааж, бэлгийн чиг баримжаанд суурилсан халдлага, заналхийллийнхэргийг мөрдөн шалгаж, яллах (Нидерланд Улс)	ХЗЯ	Хэрэгжилтийн шатанд. Гэмт хэргийн тухай хуулийн шинэ төсөлд энэ талаар дараах байдлаар томъёолон тусгасан. Хуулийн төслийн 14.1-д “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол төрх байдал, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, эрүүл мэндийн нөхцөл байдлаар нь ялгаварлан гадуурхаж, эрх, эрх чөлөөг нь хязгаарласан, тодорхой үйлдэл, эс үйлдэхүй шаардсан, заналхийлсэн бол эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.”
84.57. ЛГБТ хүмүүсийн эрхийг үр дүнтэй хамгаалахад чиглэсэн хууль тогтоомж боловсруулж, тус улсад ЛГБТ хүмүүсийг алагчилах үзлийг бий болгохыг хүний эрхийн боловсрол, мэдээллийг олон нийтэд түгээх замаар зогсоох (Швейцари Улс)	ХЗЯ, ХЭҮК, ХАХНХЯ	Хэрэгжилтийн шатанд. Хүний эрхийн Үндэсний Комисс, ЛГБТ Төвтэй хамтран НҮБХХ-ийн санхүүжилтээр Монгол Улс дахь ЛГБТ хүмүүсийн эрхийн хэрэгжилтийн судалгааг 2012 онд хийсэн. Энэхүү суурь судалгааны үр дүнг “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 12 дахь илтгэл”-д тусгаж, 2013 онд УИХ-д илтгэсэн. Дээр дурдсан Комиссын 12 дахь илтгэлийг УИХ-ын Хууль зүйн байнгын хороо авч хэлэлцэж, 2013 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 13 дугаар тогтоол гаргаж НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл, Эрүүдэн шүүхийн эсрэг хороо, Хүний эрхийн хорооноос Монгол Улсын Засгийн газарт өгсөн лесбиян, гей, бисексуал, трансжендер хүний эрхэд хамаарах зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг Засгийн газарт үүрэг болгосон. Мөн ХЭҮК хүний эрхийг хөхиүлэн дэмжих чиг үүргийнхээ дагуу НҮБ-ын дээрх зөвлөмжийн хүрээнд олон нийтийн мэдлэг ойлголтыг дээшлүүлэх чиглэлээр онцгойлон анхаарч ажиллаж байна. Энэ хүрээнд 2012 онд Ази Номхон Далайн бүс нутгийн Хүний эрхийн үндэсний байгууллагуудын Чуулганы дэмжлэгтэйгээр “Бэлгийн цөөнхийн эрхийн талаарх олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх нь” төслийг хэрэгжүүлж, ЛГБТ хүмүүсийн эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих асуудлаар олон нийтэд чиглэсэн ТВ шторк болон телевизийн баримтат нэвтрүүлгийг хийж үндэсний хэд хэдэн телевизээр дамжуулж олон нийтэд хүргэхийн зэрэгцээ ЛГБТ хүмүүсийн талаарх төрийн албан хаагчдын ойлголтыг сайжруулах чиглэлээр тогтмол сургалт, сурталчилгааны ажил хийж байна.
84.58. Бэлгийн чиг баримжаа буюу хүйсийн чиг баримжаанаас нь хамаарч хувь хүмүүст халдсан, заналхийлсэн хэргийг нарийвчлан, хараат бусаар мөрдөн шалгах явдлыг хангах, тийм гэмт хэрэг үйлдэгчдийг шийтгэх (Канад Улс)	ХЗЯ	Хэрэгжилтийн шатанд. 84.56-г харна уу.
84.59. Хүүхэд, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, өндөр настан зэрэг эмзэг бүлгийн эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих хүчин чармайлтыг дэмжих (Куба Улс)	ХАХНХЯ	Хэрэгжилтийн шатанд. 84.38-ыг харна уу.
84.60. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн талаар олон нийтийн мэдлэгийг дээшлүүлж, тэдгээрийн сонгох эрхийг хэрэгжүүлэх бүх нөхцөлийг хангах (АНУ)	СЕХ, ХАХНХЯ	Зарим нь хэрэгжсэн. 84.37, 84.100-г харна уу.
84.61. Хөгжлийн бэрхшээлтэй оюутан, сурагчдыг боловсролын системд алгуур нэвтрүүлэх зорилгоор боловсролын хөтөлбөрөө боловсруулж, хэрэгжүүлэх (Словени Улс)	БШУЯ, ХАХНХЯ	Хэрэгжилтийн шатанд. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оношлогооны журам, боловсролын үнэлгээний журмын тус тус боловсруулсан бөгөөд батлуулахаар ажиллаж байна.
84.62. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг анги танхимын хичээлд сургахыг нэмэгдүүлэхийг дэмжих боловсролын хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх (АНУ)	БШУЯ, ХАХНХЯ	Хэрэгжилтийн шатанд. 84.61-г харна уу. Уншлагын танхим, багш, суралцагчийн хөгжлийн танхим, эмчилгээний биеийн тамирын өрөө бүхий 320 хүүхдийн суудалтай сургуулийн барилгын өргөтгөлийг улсын төсвийн 1.2

		<p>тэрбум төгрөгийн санхүүжилтээр барьж дуусган Нийслэлийн Баянгол дүүргийн тусгай 70 дугаар сургуульд хүлээлгэн өгч сургалтын үйл ажиллагаа явуулах боломж нөхцлийг бүрдүүлсэн; 2013-2014 оны хичээлийн жилд тусгай сургуулийн Математик I (255ш), Монгол хэл IV(268ш), Монгол хэл IV (670ш) гэсэн сурах бичгийг зохиож, тусгай сургалттай 5 сургуульд суралцаж буй сурагчдын статистик мэдээнд үндэслэн хэвлэн нийлүүлсэн; Олон улсын дэмжлэг туслалцаа төлөөлөгчийн газрын шугамаар Харааны бэрхшээлтэй 116 дугаар сургуульд брайль принтер, хэвлэгч, бичгийн машин, линз зэрэг 46 сая төгрөгний өртөг бүхий сургалтын тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүн нийлүүлэв. Үүнд хараагүй болон сул хараатай хүүхдүүдэд зориулсан прожектор, брайль принтер, таяг, линз, брайль бичгийн цаас, томруулдаг шил зэрэг олон дэмжих хэрэгсэл, сургалтын хэрэглэгдэхүүн багтсан болно.</p> <p>“Ерөнхий боловсролын тусгай сургуульд бага дунд боловсролын тухай хуулийн 12.6-д заасан ажилтнаас гадна хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд сэргээн засах, чийрэгжүүлэх, эрүүл мэндийн анхан шатны тусламж үзүүлэх чиглэлээр мэргэшсэн эмч, сувилагч, туслах багш, сэргээн засалч, сэтгэл зүйч ажиллана” гэсэн хуульд орсон нэмэлт өөрчлөлттэй холбоотойгоор тусгай сургуулийн бага ангиуд туслах багштай болсноор ангийн багш зөвхөн хичээл сургалтдаа бүрэн анхаарал хандуулах, нэг сурагчид зарцуулах цаг ихсэх, хөгжлийн бэрхшээлтэй эцэг эхчүүдийг туслах багшийн орон тоон дээр ажиллуулах эрх зүйн орчин бүрдсэн. Мөн сэтгэл зүйч, сувилагч ажилласнаар хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад учирсан бэрхшээлийг шийдвэрлэхэд сэтгэл зүйн туслалцаа авч, эмчийн ачаалал багасах эмнэлгийн үйлчилгээг цогц байдлаар хүргэх боломжтой болно.</p> <p>“Багш боловсролын шинэчлэлийн төсөл”-ийн хүрээнд согог судлал, тусгай хэрэгцээт боловсролын багш нарын баг ажиллан “Тусгай хэрэгцээт боловсролын багш” /0140300/ бэлтгэх сургалтын нэг жилийн төлөвлөгөөг боловсруулж, 2013-2014 оны хичээлийн жилд “Тусгай хэрэгцээт боловсролын багш” мэргэжлээр 1 жилийн хөрвөх сургалтыг зохих болзол шаардлагыг үндэслэн зохион байгуулахаар болсон.</p> <p>Харааны болон сонсголын бэрхшээлтэй хүүхдийн сургуулиудад гал тогооны, эмчилгээний биеийн тамирын болон согог заслын тоног төхөөрөмж, зориулалтын тэргэнцэрийг нийлүүлсэн.</p> <p>Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 185 дугаар тогтоолоор “Тусгай хэрэгцээт боловсрол олгох сургалтын байгууллагын удирдах болон гүйцэтгэх албан тушаалтанд нэмэгдэл хөлс олгох, тусгай сургалтын байгууллагын зардал тооцох журам”-ын 3.2-т “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд тусгай хэрэгцээт боловсрол олгох сургалтын байгууллагад санхүүжилт олгохдоо нэг сурагчийн хувьсах зардлын нормативыг 3 дахин нэмэгдүүлж тооцно”, “хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сургаж байгаа ердийн цэцэрлэг, сургуульд нэгэн адил хамаарна” гэж заасан байдаг. Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй нэг суралцагчид ногдох хувьсан зардал 3 дахин нэмэгдсэнээр энгийн сургууль, цэцэрлэгт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг элсүүлэх хөшүүрэг болоод зогсохгүй тусгай сургуулийн сургалтын орчин сайжрах, нэг хүүхдэд үзүүлэх үйлчилгээ бодитоор нэмэгдэх, сайжрах давуу талтай болсон.</p> <p>Тусгай 3 сургуулийг зориулалтын өргөгч лифт бүхий автобусаар хангах, олон улсын байгууллагын тусламжаар 2 тусгай сургуулийг микро автобустай болгох ажлыг хийгээд байна.</p> <p>Баянзүрх дүүргийн 55 дугаар сургуулийн хичээлийн байранд лифт суурилуулах, 70 дугаар сургуулийн гадна зам талбайг тэргэнцэр явах зориулалтаар тус тус тохижуулсан.</p>
84.63. Цаазаар авах ялыг бүрмөсөн халах хүчин чармайлтаа үргэлжлүүлэх, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын цаазаар авах ялыг устгахад чиглэсэн нэмэлт II протоколд нэгдэн орох (Франц Улс)	ХЗЯ	<p>Хэрэгжсэн.</p> <p>84.7-г харна уу.</p>

84.64.Цаазаар авах ялыг халах арга хэмжээгээ үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, ялангуяа Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын цаазаар авах ялыг устгахад чиглэсэн нэмэлт II протоколыг сочрхон батлах(Аргентин Улс)	ХЗЯ	Хэрэгжсэн. 84.7-г харна уу.
84.65. Цаазаар авах ялыг эцэслэн халах зорилгоор хоригоо хадгалах (Герман Улс)	ХЗЯ	Хэрэгжсэн. 84.7-г харна уу.
84.66. Цаазаар авах ялыг хууль тогтоомжоосоо хасах замаар одоогийн нааштай явцын (цаазаар авах ялд хориг тавьсан) мөрөөр арга хэмжээ авах (Норвеги Улс)	ХЗЯ	Зарим хэсэг хэрэгжсэн. 84.9-г харна уу.
84.67. Цаазаар авах ялыг халах шинэ хууль тогтоомжийг аль болох түргэн баталж, хэрэгжүүлэх (Швейцари Улс)	ХЗЯ	Зарим хэсэг хэрэгжсэн. 84.9-г харна уу.
84.68. Цаазаар авах ялыг бүрмөсөн устгах зорилгоор Эрүүгийн хуулийн одоогийн заалтыг өөрчлөх (Их Британи Улс)	ХЗЯ	Зарим хэсэг хэрэгжсэн. 84.9-г харна уу.
84.69. Цаазаар авах ялыг халах зорилгоор хууль тогтоомждоо өөрчлөлт оруулах (Шинэ Зеланд Улс)	ХЗЯ	Зарим хэсэг хэрэгжсэн. 84.9-г харна уу.
84.70.Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 1 дүгээр сард зарлсан de facto хоригийг цаазаар авах ялыг бүрмөсөн устгах зорилгоор хууль тогтоомжид тусгах явдлыг хангах (Испани Улс)	ХЗЯ	Зарим хэсэг хэрэгжсэн. 84.9-г харна уу.
84.71.Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдлэг дээшлүүлэх хөтөлбөрийг бий болгох, мөн ийм хэргийг хуулийн хариуцлагаас гадуур үлдээхтэй тэмцэх чиглэлээр мөрдөн шалгах үр дүнтэй механизмыг бүрдүүлэх (Франц Улс)	ХЗЯ, УЕПГ	Хэрэгжилтийн шатанд. 84.2,84.3,84.19-г харна уу. 2011,2012, 2013 онд Монгол Улсын Эрүүгийн хуулийн 251 дүгээр зүйлд заасан “Эрүү шүүлт тулгах “ гэмт хэрэг 17 гарсныг УЕП-н дэргэдэх Мөрдөн байцаах албанаас шалгаж, прокурорын байгууллага хяналт тавьж ажилласан бөгөөд одоогийн байдлаар 3 хүн ял шийтгүүлсэн байна.Энэ төрлийн гэмт хэрэг үйлдэх явдлаас урьдчилан сэргийлэх талаар цаашид хуулийн хүрээнд холбогдох арга хэмжээ авч ажиллах болно
84.72. Эрүүдэн шүүхийн асуудлаарх тусгай илтгэгчийн өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэхэд зохих анхаарал хандуулах (Казахстан Улс)	ХЗЯ, УЕПГ	Зарим хэсэг хэрэгжсэн. Баривчлах /цагдан хорих/ байрны даац нь хэтэрсэн их хүнтэй, агааржуулалтын болон дулааны систем тааруу, бие засах өрөө болон ус хангамж хангалтгүй халдварт өвчний тархалт их байдаг талаар зөвлөмжид дурьдсан байдаг бөгөөд дээрхи ахуй нөхцлийг сайжруулахад прокуророос тавих хяналтыг сайжруулсан. Нийслэлийн Баянгол дүүргийн нутагт дэвсгэр дээр олон улсын жишигт нийцсэн "Цагдан хорих төв"-ийн барилгын ажлыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар 2007 оны 8 дугаар сард эхлүүлж 2011 оны 4 дүгээр сард хүлээн авсанаар зөвлөмжид дурьдсан зарим дутагдал арилсан болно. Түүнчлэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас2007 оноос хойши хугацаанд нийслэлийн Багануур дүүрэг болон Төв, Дорноговь, Орхон аймаг дахь Шийдвэр гүйцэтгэх албанд 2 давхар Цагдан хорих байр тус тус шинээр барьж ашиглалтад оруулсан.12аймаг дахь Шийдвэр гүйцэтгэх албадын Цагдан хорих байрны их засварын ажлыг бүрэн хийж дуусгасан. Цаашдаа 150 ялтны багтаамжтай баривчлах байрыг барихаар зураг төслийг бэлэн болгосон, цагдаагийн подвалд байрладаг 9 цагдан хорих байрыг олон улсын жишигт нийцүүлэн шинээр барих зорилттой ажиллаж байна.Монгол Улсын хэмжээнд 2012 онд цаазаар авах ялаар 9 ялтан ял шийтгүүлжээ. Цаазаар авах ялаар шийтгүүлсэн ялтнууд нь Цагдан хорих төв

		/шинээр ашиглалтанд орсон/-д хууль, тогтоомжид заасан стандарт шаардлага хангасан, 24 цагаар хяналт тавьдаг хөдөлгөөнт телекамер бүхий өрөөнд хоригдож байна. Цаазаар авах ялтай этгээдтэй Олон улсын стандартад нийцүүлэн харьцаж байгаа эсэхэд Прокурорын байгууллага эрх хэмжээнийхээ дагуу хяналтаа тавьж ажиллаж байгаа болно.
84.73. Хүч хэрэглэх эрх хэмжээг зохистойгоор хэрэгжүүлэх талаар цагдаа нарт сургалт заавал зохион байгуулж байх (Канад Улс)	ХЗЯ, УЕПГ	Хэрэгжсэн. 2012 онд “Нийтийг хамарсан эмх замбараагүй байдлын үед ажиллах дадлага, сургалтыг орон нутгийн цагдаагийн газар, хэлтэст зохион байгуулж, 21 аймгийн 2460 алба хаагч, УБ хүрээний цагдаагийн газар, хэлтсийн 2177 алба хаагч хамрагдсан байна. АНУ, ОХУ, БНХАУ, БНФУ, БНСУ, ХБНГУ, Швейцарь зэрэг гадаадын 15 улсад зохион байгуулагдсан арга хэмжээнд төв, орон нутгийн цагдаагийн байгууллагын нийт 78 ажилтан оролцсон байна. Мөнгө угаах, криминалистикийн шинжилгээ, хар тамхи, мансууруулах бодистой тэмцэх, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох, терроризмоос урьдчилан сэргийлэх, үндэстэн дамнасан гэмт хэрэгтэй тэмцэх зэрэг чиглэлээр зохион байгуулагдсан сургалт, семинарт нийт 78 албан хаагч хамрагдсан байна. Цагдаагийн алба хаагчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх ХСИС-ийн 2013 оны сургалтын төлөвлөгөөний дагуу тусгай хэрэгсэл хэрэглэх ур чадварын 18, галт зэвсэг хэрэглэх, ашиглах ур чадварын 15, хойшлуулшгүй ажиллагааны ур чадварын 13 сургалтын хичээлийн төлөвлөгөө, сэдвийг батлан сургалтыг 2013 оны 2-р сарын 25-наас эхлэн нийт 46 удаагийн сургалтад 1150 алба хаагчийг хамруулан сургаж, үр дүнгийн хэлэлцүүлгийг зохион байгуулж ажиллалаа. Мөн “Эмнести интернэйшнл”, “Дэлхийн зөн-Монгол” зэрэг ТББ-уудтай хамтран “Хүний эрх”, “Хүүхдийн гэмт хэрэг”-ийн чиглэлээр сургалт зохион байгуулж, тэдгээр сургалтад нийт 199 алба хаагч хамрагдсан. Цаашид энэ чиглэлээр тогтмол сургалтыг чиг үүргийн дагуу төлөвлөгөө, сургалтын хөтөлбөрийн дагуу зохион байгуулж байна.
84.74. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үр дүнтэй арга хэмжээ авах (Азербайжан Улс)	ХЗЯ, ХАХНХЯ	Хэрэгжилтийн шатанд. 84.17, 84.54-ыг харна уу.
84.75. Эмэгтэйчүүдийн хүчирхийллийн хэргийг мөрдөн шалгах, ийм хүчирхийлэл үйлдэгчдийг яллах, шийтгэх заалт бүхий хууль тогтоомж хэрэгжүүлэх (Шинэ Зеланд Улс)	ХЗЯ, ХАХНХЯ	Хэрэгжилтийн шатанд. 84.56-ыг харна уу.
84.76. Хамгаалуулах, нөхөн төлбөр авах боломжийг хохирогчид олгох зорилгоор Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэхэд өндөр ач холбогдол өгөх (Португали Улс)	ХЗЯ, ХАХНХЯ	Зарим нь хэрэгжсэн. 84.17, 84.54-ыг харна уу.
84.77. Жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогч эмэгтэйчүүдэд шударга шүүхээр шүүлгэх, нийгэмших, хамгаалуулах боломжийг үр дүнтэйгээр олгох баталгааг хангах арга хэмжээ авах (Бразил Улс)	ХЗЯ, ХАХНХЯ, ЖҮХ	Хэрэгжилтийн шатанд. 84.17, 84.54-ыг харна уу.
84.78. Жендэрийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай 2005 оны хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, шаардлагатай арга хэмжээ авах замаар хуулийн үр дүнг хангах, хууль зөрчигчдэд ногдуулах ялыг тодорхой тусгах (Испани Улс)	ХЗЯ, ХАХНХЯ	Хэрэгжилтийн шатанд. 84.54-ыг харна уу.
84.79. Хорих ял эдэлж буй болон цагдан хоригдож буй хүмүүсийг хамгаалах НҮБ-ын зарчим, Хоригдлуудтой харьцах НҮБ-ын наад	ХЗЯ, УЕПГ	Зарим нь хэрэгжсэн. Анхдугаар илтгэл хэлэлцүүлэх үед энэ зөвлөмж хэрэгжиж байгааг мэдэгдсэн. Улсын Ерөнхий прокурорын газрын нэгдсэн удирдамжаар хорих болон баривчлах ялын чиглэлээр 9, хорихоос

<p>захын жишиг зэргийг хэрэгжүүлэх болон бусад замаар хорих байгууллагуудын нөхцөлийг сайжруулах чиглэлээр ажиллах (Шинэ Зеланд Улс)</p>		<p>өөр төрлийн ялын чиглэлээр 5, цагдан хорих болон албадан саатуулах байранд тавих хяналтын чиглэлээр 5 шалгалт судалгааг тус тус хийж шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулахаар Цагдаагийн Ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх Ерөнхий газарт 4 шаардлага хүргүүлж биелэлтийг тооцон ажиллав</p> <p>Улсын хэмжээнд ял эдлүүлэх үйл ажиллагааг 717 шалгаж, 6228 удаа танилцаж, шалгах танилцах явцад 2323 зөрчил илрүүлж зөрчлийг арилгуулахаар прокурорын шаардлага 319 бичиж, 9 албан хаагчид эрүүгийн, 252 албан хаагчид сахилгын арга хэмжээ тооцуулж, 1303 ялтны зөрчигдсөн эрхийг сэргээсэн байна.</p> <p>Баривчлах, хорихялэдлүүлэхажиллагаанд тавих хяналтын чиглэлээр 233 удаашалгаж, 1102 удаатанилцаж, 505 зөрчиллрүүлж, зөрчлийгарилгуулахаар 103 шаардлагабичиж, 6 албанхаагчидэрүүгийн, 30 албан хаагчид сахилгынаргахэмжээтооцуулж, 500 ялтнызөрчигдсөнэрхийгсэргээсэнбайна.</p> <p>Мөнбаривчлах, хорихялэдлүүлэхажиллагаатайхолбоотойШүүхийншийдвэргүйцэтг эхалба, хорихангийндаргынгаргасан 2453 тушаалыгхянажхуульзөрчсөн 25 тушаалыгхүчингүйболгохбуюуөөрчлүүлсэнбайхбапрокурорынзөв шөөрөлгүйгээрхаруулхамгаалалтгүйгадууражиллуулсан11ялтныгх орихангидтатаноруулж, шүүхийн шийтгэхтогтоолбиелүүлэхтэйхолбоотой 2476 ялтны хувийн хэргийг хянаад 399 ялтны хувийн хэргийг буцаасан бол шүүхээр 2069 ялтны шийтгэх тогтоол биелүүлэхтэй холбоотой асуудлыг шийдвэрлүүлжээ. /Дээрх мэдээлэлд хугацаа хэрэгтэй/</p> <p>Цагданхорих, албадахбайруудынүйлажиллагаанд хууль тогтоомжийн заалт хэрхэн хэрэгжиж байдлыг 2012 онд 172 удаашалгаж, 2206 удаатанилцан 778 зөрчиллрүүлэн, зөрчлийг арилгуулахаар 101шаардлагабичиж, хариуг авч биелэлтийг нь тооцон,3 албанхаагчидэрүүгийн, зөрчил гаргасан 69 албанхаагчидсахилгынаргахэмжээ авахуулсан байна.</p> <p>Нийслэлийн цагдаагийн газрын албадан саатуулах, баривчлах төв нь үйл ажиллагаандаа Засгийн газрын 1996 оны 91 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Захиргааны журмаар албадан саатуулах байрны дэглэм, журам" Улсын Ерөнхий прокурор зөвшөөрч Цагдаагийн Ерөнхий газрын даргын 2010 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн 46 дугаар тушаалаар батлагдсан "Захиргааны журмаар баривчлах шийтгэлийг биелүүлэх журам"-ыг мөрдөн ажиллаж байна. Тус төв нь 159.7м2 талбайтай 8 өрөөтэй, 79 хүний багтаамжтай албадан саатуулах байр, 228 м2 талбайтай 13 өрөөтэй 114 хүний багтаамжтай баривчлах байр, нэг ээлжиндээ 60 хүн хооллох хоолны заал бүхий гал тогоотой нийтийн бие засах ариун цэврийн 2 өрөөтэй, гадна талбайд нийтийн бие засах газартай, нэг ээлжиндээ нийт 193 хүн хүлээн авах хүчин чадалтайгаар байгуулагдан офицер10, цагдаа 34, энгийн 23 хүн бүгд 67 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.</p> <p>Дээрх 46 дугаар тушаалаар батлагдсан журмын 2.2-т "Нийтийн өрөөнд байрлах 1 байрлагчид 2 ам метрээс доошгүй талбай ноогдохоор тооцож байрлуулна" гэж заасан. Гэтэл сүүлийн жилүүдэд тус төвд өдөрт дунджаар 250-280 хүн байрлаж, тогтоосон хэмжээнээс 90-120 хүн хүлээн авч байгаа нь байрлагсадын болон алба хаагчдын эрүүл ахуй, ажиллах орчин нөхцөлд хүндрэл учирч, журамд зааснаар хүн бүр хучлага дэвсгэрээр хангагдаж чадахгүй, хуульд заасан хүний эрх, эрх чөлөө чөрчигдөж, улмаар тэдний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байгаа зөрчлийг арилгуулахаар Чингэлтэй дүүргийн прокурорын газар 2011-2012 онд Цагдаагийн Ерөнхий газар болон Нийслэлийн Цагдаагийн газарт 10 удаа шаардлага хүргүүлээд байна. Үүний дагуу доорх ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:</p> <p>1. Нийслэлийн захирагчийн ажлын албаны инженерийн байгууламжийн хэлтэстэй хамтарсан тус төвийн уурын зуухыг</p>
--	--	--

		<p>шинэчлэх тендэр зарлаж “Рем” ХХК-аар уурын зуухны халаалтын тогоо бусад холбох хэрэгсэл, гадна дулааны шугамыг шинээр сольсоны гадна уурын зуухны засварын ажлын төсөвт төвийн халуун усны бойлер тусгагдаагүй ч өөрсдийн нөөц бололцоог ашиглан шинээр бойлерыг тавьж байрлагсадыг усанд оруулах нөхцлийг сайжруулсан байна.</p> <p>2.Төвийн барилгын дээврийн дусаал гоождог хэсэгт хэсэгчилсэн засварыг хийж, усан сангийн чайныг буулган цэвэр усыг хэрэглээнд шууд холбосон байна.</p> <p>3.Төвийн байрны хаалга, цонх дээврийг дулаалж хаалганд давхар вакум хаалга хийж, баривчлах байрны нийтийн 2 өрөөний цонхыг томсгон 3 цонх шинээр хийж, өрөөний агааржуулалт, гэрэлтүүлэг, баривчлах саатуулах байрны өрөөг засварлаж, шинээр хамгаалалтын хашааг барьж төмөр хаалга хийлгэжээ.</p> <p>4.Тус төвийн баривчлах байрны 2 давхар барилга 2009 онд цуурч, хагарал үүссэн бөгөөд энэ талаар Хууль зүйн, Цагдаагийн Ерөнхий газраас сонгон шалгаруулсан Улаанбаатар зураг төслийн “Хот айл” ХХК-аар төвийн байрны хүчитгэлийн ажлын зураг, төсвийг хийлгэж 2013 оны 4 дүгээр сард 500 хүний багтаамжтай 4 давхар байрыг шинээр баруулах зураг төсөл, хөрөнгийг нь Хууль зүйн сайдын багцаас гаргаж бариулахаар шийдвэрлэсэн байна.</p> <p>5. Баривчлах саатуулах байр болон гадна талбай зэрэг газруудад нийт 45 хяналтын камер шинээр суурилуулан тавьж, жижиүүрийн бүрэлдэхүүн, харуул хамгаалалт эрхэлсэн ажилтнууд баривчлагсадыг бүрэн хянах боломжтой болжээ.</p> <p>6.Баривчлах байранд ашиглагдаж байсан 88 тооны 2 давхар төмөр орнууд нь байрлагч нарт хүрэлцдэггүй байсан ба тэдгээр орны ихэнх нь эвдэрч ашиглалтын шаардлага хангахгүй болсон зэрэг нөхцөл шалтгааны улмаас тус төвийн захиргаа, прокурорын удаа дараагийн өгсөн шаардлагын дагуу Нийслэлийн цагдаагийн газрын удирдлагад 2012 оны 12 дугаар сард санал хүсэлт тавьж 25 сая төгрөгийн хөрөнгө гаргуулж 250 ширхэг орыг 2013 оны 1 дүгээр сарын 11-ний өдөр баривчлах байрны 13 өрөөнд угсарч хүн бүрийг ор, дэвсгэр хучлагаар хангагдах нөхцлийг бүрдүүлжээ. 2013 онд Хорих байгууллагуудын нөхцлийг сайжруулж НҮБ-ын жишигт хүргэх чиглэлээр шинээр 5 стандарт батлан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. ШШГЕГ-ын даргын 2013.04.24-ний өдрийн А/81 дүгээр тушаалаар “Үйлчилгээний стандарт”-ыг шинэчлэн баталсан. 2. ШШГЕГ-ын даргын 2013.09.25-ны өдрийн А/173 дугаар тушаалаар “ШШГБ-ын харуул хамгаалалтын албан хаагчийн ажлын байрны орчны буюу эд хогшил, техник хэрэгслийн стандарт, Хорих байгууллагын албан хаагчдын үйл ажиллагааны стандарт”; 3. ШШГЕГ-ын даргын 2013.10.17-ны өдрийн А/187 дугаар тушаалаар “Нэгдсэн эмнэлгийн бүтэц үйл ажиллагааны стандарт /Стандартын мэдээлэл, лавлагааны төв- CS11-0235:2013 бүртгэлтэй/, Тусгай мэргэжлийн сүрьеэгийн бүтэц үйл ажиллагааны стандарт /Стандартын мэдээлэл, лавлагааны төв- CS 11-0236:2013 бүртгэлтэй/, Цагдан хорих төвийн эмнэлгийн бүтэц үйл ажиллагааны стандарт -Стандартын мэдээлэл, лавлагааны төв- CS 11-0237:2013 бүртгэлтэй/, Хорих ангийн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагааны стандарт” /Стандартын мэдээлэл, лавлагааны төв- CS 11-0234:2013 бүртгэлтэй/; <p>ШШГЕГ-ын даргын 2013.11.12-ны өдрийн А/206 дугаар тушаалаар “Хоригдогсдын эрхийг хангахад чиглэсэн цагдан хорих, хорих ял эдлүүлэх ажиллагааны стандарт”;ШШГЕГ-ын даргын 2013.12.02-ны өдрийн А/214 дүгээр тушаалаар “Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны сэтгэл зүйчийн өрөөний стандарт” зэрэг болно.</p>
84.80. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй үр дүнтэй тэмцэхийн тулд илүү хүчин чармайлт гаргах (Азербайжан Улс)	ХЗЯ	<p>Хэрэгжсэн. 84.23-г харна уу. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн дагуу Хилийн чанадад хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон иргэнд туслалцаа</p>

		үзүүлэх, түр хугацаагаар орон байр, хоол хүнсээр хангах, гадаад паспорт түүнтэй адилтгах баримт бичиг олгох, эх оронд нь буцаан авчрахад шаардагдах зардал гаргах талаар журмыг 2013 оны 11 дүгээр сарын 15-нд баталсан.
84.81. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон эмэгтэйчүүд, охидыг нөхөн сэргээх, нийгэмшүүлэх зохих механизмыг бүрдүүлэх (Польш Улс)	ХЗЯ, ХАХНХЯ	Хэрэгжсэн. 84.23, 84.80-ыг харна уу.
84.82. Палермогийн протоколын заалтыг зөрчсөнийг засах зорилгоор, Хүүхдийн эрхийн хорооноос гаргасан зөвлөмжид нийцүүлэн хүн худалдах, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах үндэсний хөтөлбөрийг өргөн хүрээнд хэрэгжүүлэх (Мексик Улс)	ХАХНХЯ, ХЗЯ	Зарим нь хэрэгжсэн. МУ-ын ЗГ-ын 2005 оны 234 дүгээр тогтоолоор “Хүн худалдах ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах” Үндэсний хөтөлбөрийг батлан 2014 он хүртэл 3 үе шаттайгаар 9 жилийн хугацаатай хэрэгжүүлээд байна. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах байрны үйл ажиллагааг дэмжин ажиллаж, шаардагдах хөрөнгийг олгоод байна. Хохирогчдод халамж, үйлчилгээ үзүүлэх чиглэлээр эрүүл мэндийн нөхөн сэргээх эмчилгээ, сэтгэцийн нөхөн сэргээх эмчилгээ, ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах, хууль зүйн туслалцаа үзүүлэх, гадаад улсад МУ-ыг төлөөлөн суугаа дипломат төлөөлөгчийн болон консулын газраас хохирогчийг түр хугацаагаар орон байраар, хоол хүнсээр хангах, паспорт түүнтэй адилтгах баримт бичиг олгох, эх оронд нь буцаан авчрах зэрэг үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлэх талаар журмын төслүүдийг холбогдох яамд боловсруулан батлуулахаар ажиллаж байна. Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр бүх шатны төрийн болон ТББ-тай хамтран ажиллаж байна. Уг гэмт хэргийн талаар сэрэмжлүүлэг бүхий зурагт хуудас, шторк, паспортын хавчуурга зэрэг сурталчилгааны материалуудыг бэлтгэн хилийн боомтуудад тараагаад байна. Мөн Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаарх шторкийг Хууль зүйн үндэсний хүрээлэн, Төмөр замын LCD дэлгэцээр тогтмол цацаж байна. Азийн сангийн санхүүжилтээр хүн худалдаалах гэмт хэргийн мэдээллийн нэгдсэн санг байгуулахаар холбогдох тооцоо судалгаа хийх ажлыг эхлүүлж байна. Уг мэдээллийн сан нь төрийн байгууллагуудын мэдээллийн сан байх бөгөөд Хууль зүйн яам хариуцан ажиллана. Дэд зөвлөлийн 2013-2016 онд хийх үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг хэлэлцэн баталсан. Уг төлөвлөгөөнд заасны дагуу Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн төслийн эхний хувилбарыг боловсруулан удирдлагад танилцуулахаар бэлтгэж байна. “Хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хохирогчийг хамгаалах, халамжийн цогц үйлчилгээ үзүүлэх үйлчилгээний журам”-ыг 2013 үны 6 дугаар сарын 7-ны өдрийн А/93 тоот ХАХНХСайдын тушаалаар баталсан. Тус ажлын хүрээнд хохирогчдыг хамгаалах байрны нийтлэг шаардлага MNS6040:2009 стандартыг шинэчлэн боловсруулж Гэр бүлийн хүчирхийлэл болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогчийг хамгаалах байрны үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлага, Хүн худалдаалах гэмт хэрэгт өртөн хохирогчийг хамгаалах байрны үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлагыг тус тус 2013 оны 12 дугаар сарын 13-ны өдөр стандарт хэмжил зүйн төвөөр батлаад байна.
84.83. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдыг гэмт хэрэгт татахгүй байх, хохирогчдод нөхөн төлбөр олгох, нийгэмшүүлэх хандлагыг хэрэгжүүлэх (Мексик Улс)	ХАХНХЯ, ХЗЯ	Зарим нь хэрэгжсэн. 84.23, 84.80-ыг харна уу.
84.84. Бэлгийн болон хөдөлмөрийн мөлжлөгийн зорилгоор хүн худалдаалагчдыг яллах, хохирогчдыг хамгаалж, тусламж үзүүлэх хүчин чармайлтаа нэмэгдүүлэх (АНУ)	ХЗЯ, ХАХНХЯ	Зарим нь хэрэгжсэн. 84.23, 84.80-ыг харна уу.
84.85. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй	ХЗЯ,	Зарим нь хэрэгжсэн.

тэмцэхэд олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх кампанит ажлыг хөгжүүлэх, нэмэгдүүлэх, өргөжүүлэх (Канад Улс)	ХАХНХЯ	84.23, 84.80-ыг харна уу.
84.86. Хүн худалдаалах гэмт хэргийн эсрэг бодлогоо үргэлжлүүлэн хэрэгжүүлэх (Герман Улс)	ХЗЯ, ХАХНХЯ	Зарим нь хэрэгжсэн. 84.23, 84.80-ыг харна уу.
84.87. Хүн худалдаалах гэмт хэргийг мөрдөн шалгах, гэмт хэрэгтнийг яллах талаар институцийн(зохион байгуулалт, боловсон хүчин, нөөц хөрөнгө) чадавхийг бэхжүүлэх (Канад Улс)	ХЗЯ, ХАХНХЯ	Хэрэгжилтийн шатанд. Эрх зүйн шинэчлэлийн хүрээнд боловсруулж буй Мөрдөх албаны тухай хуульд хүн худалдаалах гэмт хэргийг мөрдөн шалгах, гэмт хэрэгтнийг яллах талаар институцийг зохицуулахаар тусгасан.
84.88. Насанд хүрээгүй хүмүүс, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгөөс үр дүнтэй хамгаалах хүчин чармайлтаа үргэлжлүүлэх (БНЧУ)	ХАХНХЯ, ХЗЯ	Зарим нь хэрэгжсэн. 84.23.84.82-ыг харна уу.
84.89. Бэлгийн мөлжлөгийн хохирогч болсон насанд хүрээгүй хүмүүс, эмэгтэйчүүдийг хамгаалах тусгай арга хэмжээг хэрэгжүүлж, хохирогчдол тусламж үзүүлэх, нэр хүндийг нь сэргээх болон тэднийг нөхөн сэргээх (БНЧУ)	ХАХНХЯ, ХЗЯ	Зарим нь хэрэгжсэн. 84.23.84.55-ыг харна уу.
84.90. Хүүхдийг бэлгийн мөлжлөгөөс сэргийлэх арга хэмжээг бэхжүүлж, бэлгийн мөлжлөг, ёс бус харьцааны хэргийг шуурхай мөрдөн шалгаж, гэмт хэрэгтнийг шийтгэх (Аргентин Улс)	ХЗЯ, ХАХНХЯ	Хэрэгжилтийн шатанд. Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд шинэчлэн боловсруулж буй Гэмт хэргийн тухай хуулийн төсөл, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн төсөл, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн төсөлд уг асуудлыг зохицуулахаар тусгаад байна.
84.91. Хүүхдийг бэлгийн мөлжлөгөөс зохих ёсоор хамгаалахгүй байгаа, хүүхдийн эсрэг үйлдсэн бэлгийн гэмт хэргийг хангалттай мөрдөн шалгахгүй байгаа, түүнчлэн хүүхдийн эсрэг бэлгийн гэмт хэрэгт яллагдагсдын тоо ийм хэрэг үйлдэгсдийн тооноос бага байгаазэрэг асуудлыг шийдвэрлэх талаар шаардлагатай арга хэмжээг аль болох түргэн авч хэрэгжүүлэх (Япон Улс)	ХЗЯ, УЕПГ, ХАХНХЯ	Хэрэгжилтийн шатанд. 84.90-ийг харна уу.
84.92. Хүүхдийн хөдөлмөрийг зогсоох талаар үр дүнтэй арга хэмжээ авах (Азербайжан Улс)	ХЯ, ХАХНХЯ	Хэрэгжилтийн шатанд. 84.15-ыг харна уу.
84.93. Хүүхдийн нөхцөл байдлыг сайжруулах хүчин чармайлтаа үргэлжлүүлэх, үүний хүрээнд хүүхдийн хөдөлмөрөөс үр дүнтэй сэргийлэхэд хүчин чармайлтаа эрчимжүүлэх (Герман Улс)	ХЯ, ХАХНХЯ	Хэрэгжилтийн шатанд 84.15-ыг харна уу.
84.94. Хүн худалдаалах гэмт хэрэг, гэр бүлийн хүчирхийлэл, эмэгтэйчүүд, охидын эсрэг бэлгийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, ийм хэргийг хуулийн хариуцлагаас гадуур үлдээхийг зогсоохчиглэлээр хууль хэрэгжүүлэх болон шүүх тогтолцоог бэхжүүлж сайжруулах (Малайз Улс)	ХЗЯ, УЕПГ, ХАХНХЯ	Хэрэгжилтийн шатанд. 84.23, 84.80-ыг харна уу.
84.95. Цагдаагийн албан хаагчдын үйлдсэн хүчирхийллийн гэмт хэргийг нягт бөгөөд хараат бусаар мөрдөн шалгах зорилгоор Улсын ерөнхий прокурорын газрын Мөрдөн байцаах хэлтсийг бэхжүүлэх (Канад Улс)	УЕПГ, ХЗЯ	Хэрэгжсэн. Улсын Ерөнхий прокурорын дэргэдэх мөрдөн байцаах алба 2012 онд УИХ-аас батлагдсан 717390,9 мянган төгрөгөөр төсвийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна. Улсын Ерөнхий прокурорын шийдвэрийн дагуу улсын прокурорын өргөтгөлийн байранд орж иж бүрэн засвар хийснээс гадна Улсын прокурорын газраас 26,6 сая төгрөгийн компьютер, бусад техник хэрэгсэл авч өгснөөс гадна тавилга, эд хогшил худалдан авах камержуулалтын

		<p>сүлжээг шинээр тавиулахад 140 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн нь ажиллагсдын идэвхи санаачилга, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүхэд чухал ач холбогдолтой арга хэмжээ боллоо.Түүнчлэн албаны төсөвт тусгагдсан 20 сая төгрөгийг конторын тохижилт тавилга, эд хогшил худалдан авснаар албаны бүх мөрдөн байцаагч, ажилтан, мөрдөн байцаалтын өрөөний эд хогшил, техник хэрэгсэл бүрэн шинэчлэгдлээ.</p> <p>2012 оны жилийн эцсийн байдлаар тус албанд хандан иргэд байгууллагаас нийт 684 гомдол, мэдээллийг ирүүлсэн ба үүнээс 121-ийг харьяаллын дагуу зохих байгууллагад шилжүүлж, гэмт хэргийн талаарх нийт 563 гомдол, мэдээлэлд зохих шалгалтыг явуулж хуульд заасны дагуу шийдвэрлэсэн байна.</p> <p>2012 онд тус алба нь хэрэг бүртгэлтийн 55, мөрдөн байцаалтын 169 нийт 246 хүнд холбогдох 224 хэргийг шалгаж үүнээс 213 хэрэг буюу 95 хувийг шийдвэрлэсэн ба хэрэг бүртгэлт явуулсан хэргийн шийдвэрлэлт 100 хувь, мөрдөн байцаалт явуулсан хэргийн шийдвэрлэлт 93.4 хувьтай байна.</p> <p>Мөрдөн байцаах албанаас хэрэг бүртгэлт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан 113 хэргийн улмаас 3.550.090.0 мянган төгрөгийн хохирол иргэд, байгууллагад учирч үүний 293.678.0 мянган төгрөгийн хохирол буюу 8.2 хувийг барагдуулж, иргэний нэхэмжлэлийг хангах, хохирол нөхөн төлүүлэх болон шүүхийн шийдвэрийн биелэлтийг хангах зорилгоор 4.431.900.8 мянган төгрөгийн хөрөнгө битүүмжлэх ажиллагаа явуулсан байна.УЕПГ-н 2014 оны нэгдсэн төлөвлөгөөнд Мөрдөн байцаах албыг бэхжүүлэх талаар тусгаж хөтөлбөр гарган ажилласан боловч УИХ-ын 2014 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 22 дугаар тогтоол гарч УЕП-ын дэргэдэх Мөрдөн байцаах албыг Авлигатай тэмцэх газарт шилжүүлэхээр шийдвэрлэсэн байна.</p>
84.96. Бэлгийн чиг баримжаанаас нь хамааран, тухайлбал ЛГБТ хүмүүсийг заналхийлсэн, халдсан бүххэргийг нягт бөгөөд хараат бусаар мөрдөн шалгаж, шударга шүүхийн олон улсын жишгийн дагуу буруутай этгээдийг шийтгэх (Швед Улс)	УЕПГ, ХЗЯ	<p>Хэрэгжилтийн шатанд. 84.56-г харна уу.</p>
84.97. Эрүүдэн шүүсэн хэрэгт хуулийн хариуцлагаас гадуур үлдэхтэй тэмцэх (Герман Улс)	УЕПГ, ХЗЯ	<p>Хэрэгжилтийн шатанд. 84.19-ыг харна уу. Тус яам Гэмт хэргийн болон гэмт хэргийн хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэ төслүүд болон Хорих ял эдлүүлэх тухай хуулийн төслийг Конвенцийн холбогдох заалтуудтай уялдуулан боловсруулж байна.</p>
84.98. Бүх шашин шүтлэгийг тэгш бүртгэх дотоодын тодорхой журам бий болгох (АНУ)	ХЗЯ	<p>Зарим нь хэрэгжсэн. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулиар зохицуулж байна. УБЕГ-аас журам боловсруулах хэрэгцээ, шаардлагыг судалж байна.</p>
84.99. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрхийг ЛГБТ хүмүүсийг алагчилахгүйгээр хангах (Швед Улс)	ХЗЯ	<p>Хэрэгжсэн. Үндсэн хуульд нийцсэн Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль хүчин төгөлдөр үйлчилж байна. ЛГБТ хүмүүсийг ялгаварлан гадуурхахыг эсрэг олон нийтийн хандлагыг өөрчлөх сурталчилгаа, мэдээллийг ХҮЭК, төрийн байгууллагууд, ТББ-уудтай хамтран зохион байгуулж байна. ХЗЯ-наас боловсруулж буй хуулийн төслийн хэлэлцүүлэгт ЛГБТ хүмүүсийн төлөөлөл, ТББ-аас саналыг байнга авч байна.</p>
84.100. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сонгох эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай зохих арга хэмжээ авах (Словак Улс)	СЕХ, ХАХНХЯ	<p>Хэрэгжсэн. - Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны сонгуулиар анх удаа санал авах байранд тэргэнцэртэй сонгогч орох боломжийг бүрдүүлэх зорилгоор зам гаргаж бэлдсэн. Сонгуулийн ерөнхий хороо Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэгдсэн холбоотой хамтран хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ялангуяа тэргэнцэртэй иргэдийг санал авах байранд өөрийн биеэр хүрэлцэн очиж саналаа өгөх боломжоор хангахад чиглэсэн тодорхой ажлууд хийлээ. Тухайлбал, хэсгийн хороодод ажлын зааварчилгаа өгч сургалт явуулахдаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн санал авах байранд орох, гарах гарцын стандартын талаар зааварчилгаа өгсний үндсэн дээр уг гарцыг хийх</p>

		<p>боломжтой хэсгийн хороодод дотоод нөөц бололцоогоо ашиглан хийсэн болно. Эдгээр ажлыг ялангуяа нийслэлийн болон аймгийн төвийн хэсгийн хороодод хийж хэрэгжүүлсэн.</p> <p>Цаашид энэ талаар шат дараалсан арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.</p> <p>- Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1903 хэсэгт брайль үсэг бүхий хавтсыг байрлуулснаар анх удаа Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны сонгуулиар хараагүй иргэд итгэмжилсэн хүний туслалцаагүйгээр бие даан саналын хуудсанд саналаа тэмдэглэж сонгох эрхээ эдэлсэн болно.</p> <p>Мөн харааны бэрхшээлтэй иргэдэд зориулан санал авах бүхээгт томруулдаг шил, ойрын харааны нүдний шил байрлуулсан.</p> <p>Түүнчлэн харааны бэрхшээлтэй иргэдийн сонгуулийн хууль тогтоомжийн талаарх боловсролд зориулж сул хараатай иргэдэд зориулсан том шриффтээр болон брайль үсгээр гарын авлага гаргаж аймаг, нийслэлд түгээлээ.</p> <p>- Сум, дүүргийн Засаг дарга нарт хуулийн дагуу хүлээлгэсэн үүргийг биелүүлэхэд дэмжлэг үзүүлж Сонгуулийн ерөнхий хорооноос сонгуулийн хэсгийн хорооны болон санал авах байрыг бэлтгэх зааврыг батлан мөрдүүлдэг бөгөөд энэхүү зааварт санал авах байранд тавигдах шаардлага, санал авах байрыг бэлтгэх талаар тодорхой зааж өгсөн. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бизнес инкубатор төв ТББ-тай хамтран сонгуулийн хууль тогтоомжийн талаар ярилцлага хийж, санал авах байрыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байлгах тал дээр сонгуулийн хороодод зориулсан зөвлөмж гарган ажиллалаа.</p> <p>Түүнчлэн УИХ-ын болон аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын 2012 оны сонгууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны сонгуулиар санал тоолох төхөөрөмжийг ямар нэгэн өндөрлөггүй байрлуулсан нь тэргэнцэртэй иргэд болон одой иргэдэд саналын хуудсаа өөрийн биеэр төхөөрөмжид хийхэд ямар нэгэн саад бэрхшээл учирсангүй.</p> <p>- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх Ерөнхий газар Сонгуулийн Ерөнхий Хорооноос өгсөн зөвлөмж болон дээрх хуульд зааснаар СМДӨЭАЗАХХГ, Цагдан хорих анги, байруудад байгаа сэжигтнүүд, шүүхийн тогтоол хүчин төгөлдөр болоогүй, захиргааны журмаар баривчлагдсан иргэдийн нэрсийн жагсаалтыг холбогдох тодорхойлолтын хамт гаргаж тухайн байгууллагыг харьяалах сонгуулийн хэсгийн хороонд хүргүүлэх ажиллагааг гүйцэтгэн тэдгээр иргэдийн сонгох эрхийг хангах арга хэмжээг авч хэрэгжүүлдэг.</p> <p>- 2012 оны 6 дугаар сарын 26-ны өдөр Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэгдсэн холбоотой хамтран гадаа талбайд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд саналын хуудсанд саналаа хэрхэн тэмдэглэх, санал тоолох төхөөрөмжтэй хэрхэн харьцах талаар үзүүлэх арга хэмжээг зохион байгуулж, үүнд харааны, сонсголын болон тулгуур эрхтэний бэрхшээлтэй иргэд, одой иргэд, тэргэнцэртэй иргэд хамрагдсан болно.</p>
84.101. Хөгжлийн бэрхшээлтэй болон цагдан хоригдсон хүмүүсийн сонгох эрхийг хэрэгжүүлэхэд шаардлагатай үр дүнтэй арга хэмжээ авах (Лалын БН Иран Улс);	СЕХ, ХАХНХЯ, ХЗЯ	Хэрэгжсэн. 84.100-г харна уу.
84.102. Шийдвэр гаргах явцад эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх (Алжир Улс)	ХЗЯ, бүх яам	Хэрэгжилтийн шатанд. 84.45-ыг харна уу.
84.103. Ядуурлыг бууруулах, хүнсний аюулгүй байдлыг дээшлүүлэх хүчин чармайлтаа үргэлжлүүлэх (Азербайджан Улс)	ХАХНХЯ, ҮХААЯ	Хэрэгжилтийн шатанд. 84.30-ыг харна уу. Хүнсний тухай хууль, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын тухай хуулийг 2012 оны 12 дугаар сарын 20-ны өдөр батлуулан хүнсний салбарын эрх зүйн орчныг шинэчилсэн. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийг батлуулснаар хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хүнсний бүх сүлжээнд хангах нөхцлийг бүрдүүлж эхлээд байна. Хуулиудын хүрээнд ҮХААЯ, ЭМЯ, МХЕГ хамтран нийт 27 журам, дүрэм, заавар, шаардлага, норм, норматив боловсруулж

		<p>батлуулахаас дараах 14 дүрэм, журмыг батлуулаад байна. “Органик хүнсний тухай” хуулийн болон “Органик хүнсний үйлдвэрлэлийг дэмжих” үндэсний хөтөлбөрийн, “Органик хүнсний үйлдвэрлэлд хэрэглэх бодисын жагсаалт”-ын төслүүдийг тус тус боловсруулсан.</p> <p>Монгол улсын хүнсний аюулгүй байдлыг сайжруулах зорилгоор “Хүнсний аюулгүй байдал” үндэсний хөтөлбөрийг 2009-2016 оны хугацаанд хэрэгжүүлэхээр Засгийн газрын 2009 оны 32 дугаар тогтоолоор батлуулан шат дараатай арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Үндэсний хөтөлбөрт Засгийн газрын 2011 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 114 дүгээр тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулсан. Хөтөлбөрийн эхний үе шат /2009-2012/-анд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээний биелэлт 78 хувьтай хэрэгжсэн ба 2 дугаар үе шат хэрэгжиж эхлээд байна.</p>
84.104. Тэжээлийн дутагдал болон сүрьеэ зэрэг өвчинтэй тэмцэх хүчин чармайлтаа сайжруулах (Бангладеш Улс)	ЭМЯ	<p>Хэрэгжилтийн шатанд.</p> <p>5 хүртэлх насны хүүхдийн өсөлт хоцролтын үзүүлэлт үндэсний түвшинд 2010 онд 2005 ба 2000 онуудтай харьцуулахад (15.3%,) нилээд огцом буурсан байна. Бууралтын явц 2005 оноос 2010 оны хооронд жил бүр 2.4%-иар буурсан үзүүлэлттэй байна. Сүүлийн 10 жилийн хугацаанд үндэсний түвшинд 5 хүртэлх насны хүүхдийн тураалын үзүүлэлт эрчтэй буурсаар байна. 2005 онд тураалын үзүүлэлт 5.3% байсан бол 2010 онд 3.3% болж буурч, 2000 оноос хойш 3.5 дахин буурсан байна.</p> <p>5 хүртэлх насны хүүхдийн туранхайн үзүүлэлт 2000 оноос хойш эрчтэй буурсан. 2005 онд 2.7% байсан бол 2010 онд 1.6% болж буурсан байна. Монгол Улсад өлсгөлөн байхгүй байна.</p> <p>2000 онд туранхайн үзүүлэлтэд хот хөдөөгийн ялгаатай байдал илэрч (хөдөөгийн хүүхэд хотын хүүхдээсээ илүүтэйгээр туранхайд өртдөг 8.2%, 5.7%) байсан бол 2005 онд дээрх ялгаатай байдал арилсан (2.8%, 2.6%) төдийгүй 2010 онд эсрэгээрээ хотын хүүхдэд туранхай үзүүлэлт илүү (1.9%, 1.3%) ажиглагдаж байна.</p> <p>2013 оны 2 дугаар сард батлагдсан 43 тоот ЭМС-ын тушаалаар “Сүрьеэгийн тархалтын судалгаа зохион байгуулах тухай” батлагдан судалгаа үндэсний хэмжээнд хийгдэхээр төлөвлөгдсөний дагуу явагдаж байна.</p> <p>2013 оны 4-5-р сард хийгдсэн “Сүрьеэтэй тэмцэх, сэргийлэх үндэсний стратегийн дунд хугацааны үнэлгээ”-нээс гарсан зөвлөмжийг тусган ажиллаж байна.</p> <p>2013 оны 12 дугаар сард Сүрьеэгийн тусламж үйлчилгээний удирдамжийг ДЭМБ-ын зөвлөмжийн дагуу шинэчлэн боловсруулж эхэлсэн бөгөөд 2014 онд батлуулахаар ажиллаж байна.</p> <p>“Сүрьеэтэй тэмцэх, сэргийлэх үндэсний стратеги”-ийг Улаанбаатар хотод хэрхэн хэрэгжиж байгаа талаар Нийслэлийн удирдах ажилтны зөвлөгөөнд асуудал оруулж энэ зөвлөгөөний шийдвэрийг үндэслэн “Сүрьеэтэй тэмцэх, сэргийлэх үндэсний стратегийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” Нийслэлийн засаг даргын 2013 оны 8 сарын 15-н өдрийн захирамж гарч, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна</p>
84.105. Нийт хүн ам, ялангуяа гэр хороололд оршин сууж буй хүмүүст эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах, зохих орон сууцтай байх, боловсрол эзэмших боломжийг олгох, ундны усны аюулгүй байдал, эрүүл ахуйг хангах (Словени Улс)	ХАХНХЯ, ЭМЯ, БШУЯ, БХБЯ	<p>Хэрэгжилтийн шатанд.</p> <p>84.30-ыг харна уу.</p>
84.106. Иргэддээ эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэх арга хэмжээгээ үргэлжлүүлэн хэрэгжүүлэх (Пакистан Улс)	ХАХНХЯ, ЭМЯ	<p>Хэрэгжилтийн шатанд.</p> <p>“Нийгмийн халамжид хамрагсад эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх журам” Эрүүл мэндийн сайдын 2013 оны 08 сарын 06-ны өдрийн №277 дугаар тушаалаар батлагдсан.</p> <p>“Эрүүл мэндийн эрхийн бичиг”-ийн хөтөлбөрийн /2010-2013 онд/ хүрээнд нийт 127,832 иргэн /нийгмийн халамжийн дэмжлэг тусалцаа зайлшгүй шаардлагатай болон орон гэргүй тэнэмэл амьдралтай иргэд/ хөнгөлөлттэй эмийн болон хоёрдогч шатлалын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамрагдсан.</p> <p>“Монгол Улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого”-ын Монголын Улсын хөгжлийн 5</p>

		<p>дугаар тэргүүлэх чиглэлийн хүрээний Стратегийн зорилт 3-т “Усны нөөцийг бохирдол, хомсдолоос хамгаалах, зохистой ашиглах, хүн амыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн усаар хангах нөхцлийг бүрдүүлэх үүднээс “Ус” үндэсний хөтөлбөрийг 2010-2021 он хүртлэх хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 2010 оны 304 дугаар тогтоолоор Монгол Улсын Засгийн газраас баталж, уг хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулахад анхаарлаа хандуулж эхлээд байна. Орчны эрүүл мэндийн үндэсний хөтөлбөрийн 2 дахь үе шат 2010-2015 оны хүртэл хэрэгжиж байгаа бөгөөд хүн амыг аюулгүй найдвартай ундны усаар хангах, сайжруулсан ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх, хүн амд эрүүл ахуйн боловсрол олгох асуудал тэргүүлэх чиглэл болж байгаа.</p> <p>ЭМС, БОАЖС-ын хамтарсан 2011 оны 32 тоот тушаалаар Ус, Ариун цэвэр, Эрүүл ахуйн ажлын хэсгийг байгуулж байгаль орчин, ус, эрүүл мэндийн чиглэлээр ажилладаг 10 гаруй байгууллагын төлөөллийг оруулснаар салбар дундын хамтын ажиллагаа сайжирсан.</p> <p>Мөн хүн амд зориулсан ариун цэвэр, эрүүл ахуй, уур амьсгалтын өөрчлөлтээс шалтгаалсан усны хомсдол, эрүүл мэндийн сөрөг үр дагавраас сэргийлэх чиглэлээр ном, телевизийн нэвтрүүлэг, видео материалыг боловсруулан 40000 орчим хүн амын тодорхой зорилтот бүлэгт чиглэсэн интервенцийг явуулсан байна. Сумын эрүүл мэндийн сайн дурын ажилтанд зориулсан “Эрүүл аж төрөх ёс” сэдэвт гарын авлагыг боловсруулан 8 аймгийн 26 суманд сайн дурын ажилтан бэлтгэсэн.</p> <p>Эрүүл мэндийн ажиллагсдад зориулсан “орчны эрүүл мэндэд суурилсан эрүүл мэндийн анхан шатны тусламж”, “эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийн 3-н үе шаттай сургалтын тогтолцоог бүрдүүлэн, сургагч багш нарыг бэлтгэн, сүүлийн 3-н жилийн хугацаанд 300 гаруй эрүүл мэндийн ажиллагсадыг сургалтанд хамруулаад байна.</p> <p>ДЭМБ-ын дэмжлэгтэйгээр 8 аймгийн 26 суманд хэрэгжүүлсэн төслийн хүрээнд 8 сумын эрүүл мэндийн төвд цэвэр ус хангамжийг сайжруулах /гүний худаг, цэвэр усны холболт/, 10 сумын эрүүл мэндийн төвд сайжруулсан агааржуулалттай жорлон барих ажлыг хийлгүүлсэн. Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийг сайжруулах зорилгоор төсөлд хамрагдсан 26 сумын эрүүл мэндийн төвийг 16 нэр төрлийн багаж хэрэгслээр хангасан.</p> <p>ЭМЯ, ДЭМБ-ын дэмжлэгтэйгээр 2011 оноос Усны аюулгүй байдлын төлөвлөгөө хэмээх усны эх үүсвэрээс хэрэглэгч хүртэлх бүх цэгийн эрсдлийг хянах, эрсдлээс урьдчилан сэргийлэх энэхүү үр дүнтэй аргыг Монгол Улсад санаачлан хэрэгжүүлж байна. Энэхүү шинэ ойлголтыг түгээх талаар 2011 оноос усны аюулгүй байдлын төлөвлөгөөг /УАБТ/ улсын түвшинд хэрэгжүүлэх “Хөтөч” болон “Хотын болон Жижиг суурин газрын ус хангамжийн УАБТ” зэрэг 3 гарын авлагыг орчуулан хэвлүүлж, ус хангамжийн болон НЭМ-ийн мэргэжилтэнүүдэд 6 удаагийн сургалт-семинарыг зохион байгуулж, үндэсний хэмжээнд 74 сургагч багшийг бэлтгэж, улмаар УАБТ-ний алсын хараа, стратеги зорилт, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлоод байна.</p>
84.107. Үндэсний боловсролын болон эрүүл мэндийн тогтолцоог хөгжүүлэхэд хувийн хэвшлийн оролцоог түлхүү нэмэгдүүлэхэд анхаарах (Лалын БН Иран Улс)	БШУЯ, ЭМЯ	<p>Хэрэгжилтийн шатанд.</p> <p>Эрүүл мэндийн боловсрол олгож буйхувийн хэвшлийн дээд сургууль 4, коллеж 1 тус тус ажиллаж байна. 2010-2011 онд Төрийн болон хувийн хэвшлийн Анагаах ухааны сургуульд 21 доктор, 68 магистр, 1695 бакалавр, дипломын 940 хүн боловсрол эзэмшсэн байна.</p> <p>Эрүүл мэндийн сайдын 2009 оны 444 дүгээр тушаалаар төрийн бус байгууллагаар мэргэжлийн зэргийн шалгалтыг зохион байгуулах эрх олгож нийгэмлэг, холбоодыг тусгай шалгуурын дагуу шалгаруулсан. Мэргэжлийн зэргийн шалгалт зохион байгуулах эрх авсан 3 холбоо, Мэргэжлийн зэргийн шалгалт зохион байгуулах эрх авсан 14 нийгэмлэгүүд үйл ажиллагаа явуулж байна.</p> <p>Мөн “Монголын хөнгөвчлөх эмчилгээний нийгэмлэг”, “Монголын</p>

		зүрхний хэт авиа оношлогооны нийгэмлэг”, “Монголын хэт авиа оношлогооны нийгэмлэг” зэрэг нийт 32 төрийн бус байгууллага давтан сургалт, эмнэлгийн мэргэжилтний багц цаг бүрдүүлэлтийн сургалтыг нийт 40 сэдвээр зохион байгуулж, 13936 мэргэжилтнийг хамруулсан байна.
84.108. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үр нөлөөг сайжруулах, үүний хүрээнд холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгох, байгаль орчны бохирдол, муудалтын үр дагаварын талаар нийтэд мэдээлэл, боловсрол, мэдлэг олгох (Малайз Улс)	БОНХЯ, ЭМЯ	<p>Хэрэгжилтийн шатанд. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үр нөлөөг сайжруулах зорилгоор 2012 оны 05 дугаар сарын 17-нд салбарын 8-н хуулийг шинэчлэн найруулж, нэмэлт өөрчлөлт оруулж, 2 хуулийг шинээр боловсруулан батлуулсан. Тус эрх зүйн шинэчлэлийн хүрээнд дараах зарчмын асуудлууд тусгагдсан. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Бохирдуулагч нь хохирлыг нөхөн төлөх. Байгаль орчны тэнцвэрт байдлыг алдагдуулсан, хохирол учруулсан этгээд нөхөн төлбөр төлөх замаар тухайн хохирлыг арилгах, нөхөн сэргээх санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлсэн. 2. Хамгаалагч нь ашиглах. Нутгийн иргэд байгалиа хамгаалж, түүний нөөц баялгийг өсгөн үржүүлж түүний үр шим, тухайн баялгийг давуу эрхтэйгээр ашиглах боломжийг бүрдүүлсэн. 3. Олон нийтийн оролцоог хангах. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний явцад тухайн төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэд, оршин суугчдын саналыг авч байхаар зохицуулсан ба энэ нь нутгийн иргэдийн эрх ашиг зөрчигдөхөөс хамгаалах ач холбогдолтой юм. <p>Байгаль орчны нөхөн сэргээлт болон уур уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн 8 стандартыг боловсруулан батлуулах ажил хийгдэж байна. Байгаль орчны доройтлоос урьдчилан сэргийлэх, хайрлан хамгаалах мэдлэг, мэдээлэлтэй иргэнийг бэлдэх зорилгоор БОНХЯ-аас 2013 оныг “Байгаль орчны боловсролыг дэмжих жил” болгон зарлаж, тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.</p>
84.109. Дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлтөөс болон хүний буруутай үйл ажиллагаанаас үүдэлтэй, ялангуяа эрүүл ахуйн тогтолцооны талаарх тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд үйл ажиллагааны үндэсний хөтөлбөр боловсруулах зэргээр цаашид зохих арга хэмжээ авах (Иран Улс)	БОНХЯ	<p>Хэрэгжилтийн шатанд. “Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр”-ийг УИХ-ын 2011 оны 2 дугаар тогтоолоор батлуулсан. “Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөрийн эхний үе шатанд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг” ЗГ-ын 2011 оны 317 дугаар тогтоолоор батлуулсан. “Уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, дасан зохицох, хүний эрүүл мэндийг хамгаалах стратеги” /2011-2015/-ийг түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хамт Эрүүл мэндийн сайдын 2011 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн 404 дүгээр тушаалаар батлуулсан. Уг хөтөлбөр хэрэгжсэнээр Монгол Улсад байгаль, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж бүрдэнэ. НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөр, Дасан зохицох сангийн 5,5 сая ам.долларын санхүүжилттай “Экосистемд түшиглэсэн дасан зохицох арга хэмжээг уур амьсгалын өөрчлөлтөд өндөр эрсдэлтэй голуудын сав газарт хэрэгжүүлэх нь” төслийг Монгол орны экосистемийн хувьд харилцан адилгүй Хархираа-Түргэн, Улз голын сав газарт хэрэгжүүлж байна.</p>
84.110. Иргэдийн сурч боловсрох эрх, эрүүл мэндээ хамгаалуулах эрхийг хангах хөтөлбөр, арга хэрэгслийг хэрэгжүүлэх (Куба Улс)	ЭМЯ, БШУЯ	<p>Хэрэгжилтийн шатанд. Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн 1-ХМ ангийн “Эрүүл мэнд” хичээлийн агуулгын хүрээ, сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах ажил 2013 онд бүрэн хийгдэж дуусаад сургалтад мөрдөж байгаа. Энэхүү сургалтын хөтөлбөр, сурах бичиг, гарын авлага, зөвлөмжийг боловсруулах, хөтөлбөрийн агуулгад экспертиз хийх, хэлэлцүүлэг зохион байгуулах ажилд их, дээд болон ерөнхий боловсролын сургуулийн мэргэжлийн багш нар, эрүүл мэндийн чиглэлээр сургалт, үйл ажиллагаа эрхэлдэг төрийн болон төрийн бус байгууллага(Монфемнет, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв гэх мэт)-ын төлөөллийг татан оролцуулсан болно. Эрүүл мэндийн багш нарт зориулсан сургалтыг үндэсний, бүсийн, орон нутгийн түвшинд зохион байгуулж, эрүүл мэндийн хичээлийг албан болон албан бусаар зааж буй нийт 182 багшийг хамруулан өсвөр үеийнхнийг эрүүл мэндээ дэмжих эерэг зан үйлтэй болоход дэмжлэг үзүүлэх, эрүүл мэндийн орчин үеийн сургалтын арга</p>

		<p>технологид суурилсан сургалтын арга зүйн чиглэлээр тэдний мэргэжил арга зүйг дээшлүүлсэн.</p> <p>Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн 1-ХИ ангийн “Эрүүл мэнд” сургалтын хөтөлбөрийг 2012 онд боловсруулж албан сургалтад, “Албан бус боловсролын эрүүл мэндийн сургалтын хөтөлбөр”, сургалтын нэмэлт гарын авлагыг боловсруулан албан бус боловсролын сургалтад тус тус мөрдөж байна.</p> <p>Улсын хэмжээний ерөнхий боловсролын болон албан бус боловсролын төвийн “Эрүүл мэнд” хичээлийг зааж буй багш нарыг хамруулсан мэргэжил дээшлүүлэх сургалтыг зохион байгууллаа.</p> <p>2012 онд баталсан “Насан туршийн боловсролын талаар баримтлах чиглэлд иргэнд эрүүл мэндийн боловсрол олгох нь насан туршийн боловсролын гол чиглэл байх”-аар тусгасан бодлого төлөвлөлтийн дагуу эрүүл мэндийн боловсролын чиглэлээр “Амьдрах ухаанд суурилсан эрүүл мэндийн боловсрол” 2 сургалтын хөтөлбөр, 2 багшийн гарын авлага, суралцагчдад зориулсан 4 гарын авлага боловсруулан хэвлэж, Насан туршийн боловсролын Гэгээрэл төвүүдээр түгээх, 3 зурагт хуудас бүхий “Бэлгийн замаар дамжих халдвар” сэдэвт 13 минутын нэвтрүүлгийг бэлтгэн теле-онлайн сургалтыг зохион байгуулах ажлыг тус тус хийлээ.</p>
84.111. Сургуулиас завсардах (ялангуяа эрэгтэй хүүхдүүд)-ын эсрэг нэмэлт арга хэмжээ авах (Алжир Улс)	БШУЯ	<p>Хэрэгжилтийн шатанд.</p> <p>Улсын хэмжээнд аймаг, нийслэлийн түвшинд сургуулиас гадна байгаа 11636 иргэдийг дүйцсэн хөтөлбөрийн сургалтад хамруулсанаас бага боловсролд-4153, суурь боловсролд-3681, бүрэн дунд боловсролд- 3799 иргэд суралцаж байна.</p> <p>2013 онд “Бичиг үсгийн боловсрол” сургалтаар 2101 хүн бичиг үсэгт шинээр тайлагдаж, 1763 хүн бичиг үсгийн чадвараа ахиулсан.</p> <p>Насан туршийн боловсролын үндэсний төвөөс “Дүйцсэн сургалтын модуль”-ийг цахим хэлбэрт оруулах, бага боловсролын 20 төрлийн модулийг тус бүр 1000 ширхэг, нийт 20 000 ширхэг хэвлүүлж түгээх ажлыг хийсэн.</p> <p>НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран хэрэгжүүлж буй “Дүйцсэн хөтөлбөр” дэд төслийн хүрээнд Амарбаясгалант, Эрдэнэмандал, Гандантэгчилэн хийд, Завхан аймгийн Улиастай сумын сүм хийдэд шавилан суугаа 282 /давхардсан тоогоор/ лам хөвгүүдийг боловсрол нөхөн олгох дүйцсэн хөтөлбөрийн 60 хоногийн сургалтад хамруулсан.</p>
84.112. Сургуулийн боловсролын хөтөлбөрт хүний эрхийн сэдвийг тусгах хүчин чармайлтаа эрчимжүүлэх (Турк Улс)	БШУЯ	<p>Зарим нь хэрэгжсэн.</p> <p>Ерөнхий боловсролын 12 жилийн Нийгмийн ухааны сургалтын хөтөлбөр, X-XII ангийн нийгмийн ухааны хичээлийн агуулгын хүрээг боловсруулан сургалтад мөрдөж байна. Энэхүү хөтөлбөрт “Эрх зүй” бүлэг сэдвийн хүрээнд хүний эрх, эрх чөлөө, хүүхдийн эрх, ёс зүй, соёл, хүчирхийлэл, хүйсийн тэгш харилцаа зэрэг агуулгыг багтаан VII-XII ангийн сурагчид долоо хоногт 1-2 цагт багтаан судалдаг. Үүний зэрэгцээ энэ онд X ангийн сурах бичгийг нөхөн хангалт хийх, XI ангийн сурах бичгийг шинээр зохион бүх сургуулиудад хэвлэн түгээсэн.</p> <p>2013 онд “Хүүхдийн эрх”, “Жендерт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт түүх, нийгмийн ухааны багш нарын мэргэжил арга зүй, чадавхийг дээшлүүлэх сургалтууд 2 үе шаттай зохион байгуулсан.</p> <p>“Жендерээс үүдэлтэй хүчирхийллээс сэргийлэх”, “Хорт зуршлаас сэргийлэх” сургалтын модуль хөтөлбөрийг боловсруулан сургалтын нэмэлт хэрэглэгдэхүүн болгон ашиглахын зэрэгцээ нийгэмд тогтсон хүүхдийн эрхийн хэм хэмжээ, салбар хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулах, дотуур байрны орчин дахь хүчирхийлэл болон хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэхэд авах арга хэмжээг эрчимжүүлэх үүднээс “Жендерт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх боломж” сэдэвт уулзалтыг зохион байгуулж, сургалтын хөтөлбөрийг дахин сайжруулахдаа хүүхдийн эрх, жендерт суурилсан хүчирхийллээс сэргийлэх агуулгыг нарийвчлан сайжруулах шаардлагатай байгаа талаар хэлэлцлээ. Энэ онд Боловсролын стандарт, хөтөлбөрийг</p>

		<p>шинэчлэх ажилтай холбоотойгоор Нийгмийн ухааны хичээлийн агуулгыг шинэчлэх явцад “Эрх зүй” агуулгыг сайжруулах ажил хийгдэнэ.</p> <p>Ерөнхий боловсролын сургуулийн шинээр зохиогдсон VI, XI ангийн сурах бичигт жендерийн мэдрэмж, тэгш байдлын талаар хөндлөнгийн шинжээч ажиллуулж, агуулга, зураг дүрслэлийн хувьд жендерийн асуудлыг онцгой анхаарч засаж сайжруулсан.</p>
84.113. Уугуул иргэд болон омог, отгоор амьдардаг хүмүүст зохих хамгаалалт үзүүлэх (Словени Улс)	ХАХНХЯ	<p>Хэрэгжсэн.</p> <p>ХЭҮК-ын зөвлөмжийн дагуу дэмжлэг шаардлагатай ястан нь цаатан юм.</p> <p>Яамд чиг үүргийн дагуу тодорхой үйл ажиллагааг хэрэгжүүлсэн.</p> <p>-Цаа бугын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах зорилтын хүрээнд тус аймгийн Хатгал тосгонд нийт 11 толгой цаа буга, буга согоог 2012 оны 1 дүгээр улиралд ээмэгжүүлэн бүртгэж, гэрчилгээ олгох ажлыг зохион байгуулав. Цаанд урьдчилан сэргийлэх тарилга, туулгалтыг жил бүрийн 5, 10 дугаар сард 2 удаа хийж байна.</p> <p>-Аж ахуйн орлогын эх үүсвэр нь цааны аж ахуй, ан гөрөө, байгалийн баялаг байсаар ирсэн бөгөөд энэ хөтөлбөрийг хэрэгжүүлсний үр дүнд цаачин иргэд тодорхой хэмжээний малтай, унааны морьд, үхэртэй болж аж ахуй эрхлэх хэлбэр нь агуулгын хувьд нилээн өөрчлөгдсөн.</p> <p>-Цаа бугын аж ахуйг эрхэлж амьдардаг цаачин иргэдийн нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх зорилтын хүрээнд баруун тайгад 2 айлын орон сууц барьсны зэрэгцээ баруун, зүүн тайгад амьдардаг 52 өрхөд тус бүр нь 50.0 мянган төгрөгийн үнэтэй 52 ширхэг радио хүлээн авагч олгов.</p> <p>-Цаан сүргийн тоо толгой өсч 1500 орчим болж, цаачин иргэдийн 55 хүүхэд, залуучууд их, дээд сургуульд, 8 хүүхэд МБС-иудад суралцаж байгаа ба анхны мэргэжилтэн сургуулиа амжилттай төгсөн сумандаа малын эмч мэргэжлээр ажиллаж байна.</p> <p>-2013 онд Туркийн Олон улсын хамтын ажиллагааны агентлагийн нийт 35,0 мянган ам.долларын санхүүжилтээр ОХУ-ын Тува улсаас үржлийн өсвөр 20 цаа худалдан авах тохиролцоог хийж, гэрээ байгуулсан. Цааг 2014 оны 5 дугаар сард Монголд оруулж ирэхээр холбогдох арга хэмжээг зохион байгуулж байна.</p> <p>-ХАХНХ-ын сайд, ҮХАА-н сайдын хамтарсан тушаалаар ажлын хэсэг байгуулан 2013 оны 4 дүгээр сард Хөвсгөл аймгийн Цагааннуур суманд ажиллаж цаатан иргэд, холбогдох сумын удирдлагаас тавьсан саналын дагуу асуудал боловсруулан Засгийн газрын 2013 оны 168 дугаар тогтоолыг батлууллаа. Тогтоолоор цаатан хүүхдэд болон насанд хүрсэн иргэдэд 2013 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн сар бүр мөнгөн тэтгэмж олгох ажлыг зохион байгуулахаар болж, 2013 онд уг тэтгэмжийг олгоход шаардагдах 252,0 сая төгрөгийг шийдвэрлүүлэв.</p> <p>-Цаатан иргэдийг нарийн мэргэжлийн эмч нарын урьдчилан сэргийлэх үзлэгт жил бүр 2-оос доошгүй удаа үнэ төлбөргүй хамруулж байна. Хөвсгөл аймгийн Цагааннуур суманд 2013 оны 16/IV-19/IV өдрүүдэд эмэгтэйчүүд, мэс засал, хэт авиан, дотор, хүүхдийн зэрэг нарийн мэргэжлийн эмч, мэргэжилтнүүдийн баг ажиллаж, зүүн, баруун тайга болон сумын төвийн иргэдэд урьдчилан сэргийлэх үзлэг хийн нийт 323 хүнийг хамруулсан. Тус баг нь газар дээр нь асуудлыг шийдэж эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлсэн байна.</p> <p>-Цаатан иргэдэд үйлчилж байгаа багийн эмчийг унаатай болгож, 2 жил тутам шинэчилж байна.Цаатан иргэдэд үйлчлэх эмнэлгийн ажилчдын тоог нэмэгдүүлэв.</p> <p>-0-16 насны хүүхдийг жилд 2 удаа витаминжуулах арга хэмжээ авч байгаа бөгөөд хүүхдийн өвчний чиглэлээр 70 хүүхдийг үзлэгт хамруулсны 26 нь тайгад, 44 нь сумын төвд амьдардаг хүүхдүүд байв.</p> <p>Малчдын эрх зүйн байдлыг баталгаажуулах талаар БХБЯ-наас Газрын шинэтгэлийн хороо байгуулсан бөгөөд Газрын тухай хуулийн төслийг шинээр боловсруулж байна. Уг хуулийн төсөлд бэлчээрийн эрх зүйн зохицуулалтын тухай тусгаад байна.</p>
84.114. Улс орны нийгмийн болон	ЭЗЯ,	Хэрэгжилтийн шатанд.

эдийн засгийн хөгжлийн стратеги, төлөвлөгөөг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх (Куба Улс)	бусад яамд	УИХ-аас батлагдсан эдийн засаг, нийгмийн хөгжлийн Үндсэн чиглэл, Засгийн газрын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг яамд улирал бүр тайлагнан ажиллаж байна. МУ-ын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлогын хэрэгжилт, мөн бусад Үндэсний хөтөлбөрийн биелэлтийг жил бүр Засгийн газарт тайлагнаж байна. МХЗ-ын хэрэгжилтийн тав дах илтгэлийг ЭЗЯ 2013 онд хүргүүлсэн.
84.115. Олон улсын хамтын нийгэмлэгийн дэмжлэгтэйгээр бэрхшээлтэй асуудлыг даван туулах талаар үргэлжлүүлэн ажиллах (Бангладеш Улс)	ГХЯ	Хэрэгжилтийн шатанд. НҮБ-ын нэн ядуурал ба хүний эрх, бизнес ба хүний эрхийн асуудлаархи тусгай илтгэгч нарыг Засгийн газрын урилгаар айлчлуулж, хамтран ажиллаж, зөвлөмжийг нь хүлээн авч, хэрэгжүүлэх чиглэлээр ажиллаж байна. Мөн эрүүдэн шүүх, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, хүүхдийг худалдах, хүний эрхийг хамгаалан тэмцэгчид, соёлын эрх зэрэг олон асуудлаар тусгай илтгэгч нартай хамтран ажиллаж байна.
84.116. Ард түмнийхээ бүх төрлийн хүний эрхийг бүрэн хамгаалах, дэмжих зорилгоор НҮБ болон түүний төрөлжсөн байгууллага, олон улсын хамтын нийгэмлэгээс зохих техникийн туслалцаа, хамтын ажиллагаа хүсэх (Малайз Улс)	ГХЯ	Хэрэгжилтийн шатанд. 84.115-г харна уу.
84.117. Хүүхдийн хөдөлмөртэй тэмцэхэд Олон улсын хөдөлмөрийн байгууллага зэргээр дамжуулан олон улсын туслалцаа эрэлхийлэх, хүсэх (Бразил Улс)	ХЯ, ГХЯ	Засгийн газраас 2011 онд баталсан Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах 2012-2016 оны үйл ажиллагааны үндэсний хөтөлбөрийг боловсруулахад Олон улсын хөдөлмөрийн байгууллагын дэмжлэгийг авсан. ОУХБ мөн Үндэсний статистикийн газраас 2011/2012 оны хүүхдийн хөдөлмөрийн үндэсний судалгааг бэлтгэн 2013 онд гаргахад дэмжлэг үзүүлсэн. Түүнчлэн ОУХБ-ын төлөөлөгчийн газар хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг үндэсний сүлжээгээр дамжуулан ажил хийж буй хүүхдүүдэд зөвлөх үйлчилгээ үзүүлсэн. Хүүхдийн хөдөлмөрийн эсрэг дэлхийн өдрийг 6 дугаар сарын 12-д тэмдэглэхэд үндэсний байгууллагад тусалдаг.
84.118. Иргэдийнхээ эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг шуурхай хангах үүднээс олон улсын түвшний техникийн хамтын ажиллагааг эрэлхийлэх (Пакистан Улс)	БОНХЯ, ЭМЯ, ГХЯ	Хэрэгжсэн. Ус, ариун цэврийн байгууламжийн асуудал эрхэлсэн байгууллагуудын удирдлага, зохион байгуулалт, бүтцийг сайжруулах, төсөлд хамрагдах сум, орон нутгийн иргэдийг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ундны ус, сайжруулсан ариун цэврийн байгууламжаар хангах замаар тэдний амьдрах нөхцлийг дээшлүүлэх, усны эх үүсвэрийг хамгаалах, зохицуулах механизмыг бэхжүүлэх зорилгоор НҮБХХ, НҮБ-ийн Хүний аюулгүй байдлын итгэлцлийн сангаас санхүүжиж буй 2 703 679 ам долларын өртөгтэй. "НҮБ-ийн Ус хангамж, ариун цэврийн байгууламжийн хамтарсан хөтөлбөр"-ийг БОНХЯ, БХБЯ, ҮХААЯ, ЭМЯ-тай хамтран хэрэгжүүлж байна. Монголын Үндэсний биоаюулгүй байдлын тогтолцоог бий болгож үйл ажиллагааг нь хангах, Биоаюулгүй байдлын Картагены протоколын талын үүргээ биелүүлэхэд нь дэмжлэг үзүүлснээр улс орны тогтвортой хөгжилд орчин үеийн биотехнологийг аюулгүй хэрэглэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Даян дэлхийн байгаль хамгаалах сангийн санхүүжилтээр нийт 714,300 ам долларын өртөг бүхий "Биоаюулгүй Байдлын Чадавхийг Бэхжүүлэх" төсөл/GFL-2328-2716-4B95/-ийг 2011.05.01–2014.04.30 хугацаатайгаар хэрэгжүүлж байна.

<p>86.4. Арьс үндсээр алагчилах бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенц, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Эмэгтэйчүүдийн алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенц зэрэгт тусгагдсан хувь хүний гомдол хянан шийдвэрлэх механизмыг хүлээж авах боломжийг судлах (Бразил Улс)</p>	<p>ГХЯ, ХЗЯ, ХАХНХЯ</p>	<p>Хэрэгжилтийн шатанд. Монгол Улс хувь хүний гомдол хянан шийдвэрлэх механизмтай холбоотой Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын I протоколд 1991 онд, Эмэгтэйчүүдийн алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн нэмэлт протоколд 2002 онд нэгдэн орсон. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцийн 22 дугаар зүйлийн дагуу мэдэгдэл гаргах асуудлыг ХЗЯ судалж байна. Арьс үндсээр алагчилах бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенцийн 14 дүгээр зүйлийг хүлээж авах боломжийг судалж байна.</p>
<p>86.5. Аливаа үндэслэлээр, түүний дотор ХДХВ/ДОХ-ын байдлаар алагчилах үзлийг шууд хориглох, урьдчилан сэргийлэх, шийтгэх, устгах зорилгоор үр дүнтэй арга хэмжээг түргэн авч хэрэгжүүлэх, шаардлагатай хууль тогтоомжийг батлах (Мексик Улс)</p>	<p>ХЗЯ, ЭМЯ</p>	<p>Хэрэгжилтийн шатанд. 84.17, 84,56-г харна уу.</p>
<p>86.6. “А” үнэлгээтэйгээр магадлан итгэмжлэгдсэн ХЭҮК нь жендерийн тэгш байдлын тухай хууль боловсруулах, түүнийг хэрэгжүүлэхэд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэвэл зохино (Унгар Улс)</p>	<p>ХЭҮК</p>	<p>Зарим нь хэрэгжсэн. 86.17-г харна уу. 2011 оны 2 сард УИХ-аас батласан “Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай” хуулийн 23, 24, 26 дахь заалтуудад Хүний эрхийн үндэсний комиссын гүйцэтгэх чиг үүргийг тусгасан. Тус хуулийн дагуу Хүний эрхийн үндэсний комисс жендерийн эрх тэгш байдлыг зөрчсөн тухай гомдол хүлээн авч шийдвэрлэх, Монгол Улсын олон улсын гэрээнд заасан жендерийн эрх тэгш байдлын тухай заалтын хэрэгжилтэнд хөндлөнгийн хяналт тавьж, энэ тухай УИХ-д хоёр жил тутам илтгэж байх үүрэг хүлээсэн. Энэ чиг үүргийн дагуу Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай Монгол Улсын хуулийн 11 дүгээр зүйлд заасан хөдөлмөрийн харилцаан дахь жендерийн эрх тэгш байдал төр, хувийн хэвшил болон бусад салбарт хэрхэн хангагдаж буй байдалд үнэлэлт дүгнэлт өгч, хуулийн хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр санал зөвлөмж, боловсруулж 2013 оны “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл”-ийн хүрээнд УИХ-д тайлагнахаар ажиллаж байна. Жендерийн тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд хуулийг хэрэгжүүлэх болон хяналт тавих үндэсний чадавхийг бэхжүүлэх, хуулийг олон нийтэд сурталчлан таниулах, төрийн албан хаагчдын мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх асуудал чухлаар тавигдаж байна. Иймд Комисс 2013 онд энэ чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Европын Комиссын гишүүн Херта Даублер-Гмелинний Комисст урьж ЖТБХҮХ-ны гишүүдийг чадавхжуулах сургалт, Жендерийн тэгш эрхийн асуудлаар УИХ-ын эмэгтэй гишүүдтэй, Хүний эрхийн дэд хороог Хүний эрхийн байнгын хороо болгох асуудлаар лобби уулзалтыг УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны зарим гишүүнтэй тус тус хийв. • Комисс ажилтнуудынхаа болон иргэний нийгмийн байгууллагуудыг мөн энэ чиглэлээр чадавхжуулах зорилгоор ЕАБХАБ-ын Ардчилсан институт ба хүний эрхийн газараас мэргэжилтэн урьж “Эмэгтэйчүүдийн эрх, жендерийн эрх тэгш байдал ба хүний эрхийн мониторинг” сэдэвт сургалтыг зохион байгуулав. <p>Монфемнет ТББ-тай хамтран Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенц ба түүний нэмэлт протоколын дагуу гомдол гаргах механизмыг хөхиүлэн дэмжих зорилгоор хуульчдад болон иргэний нийгмийн байгууллагын ажилтнуудад зориулж, тус конвенцийн нэмэлт протокол болон гомдол гаргах процессын тухай сургалтыг зохион байгуулав.</p>
<p>86.7. Шийдвэр гаргах дээд албан тушаалд эмэгтэйчүүдийг оролцуулах</p>	<p>Бүх яам</p>	<p>Хэрэгжилтийн шатанд. 2011 оны 2 дугаар сарын 2-ны өдөр батлагдсан Жендерийн тэгш</p>

(Норвеги Улс)		байдлыг хангах тухай хуульд энэ талаар заалт туссан. Тус хуулийн дагуу төрийн байгууллага бүр жендэрийн асуудал хариуцсан албан хаагчтайгаар үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд албан хаагчдын хүйсийн харьцааг бүрдүүлэхэд анхаарч байна.
86.8. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, бэлгийн чиг баримжаа болон хүйсийн чиг баримжаагаар алагчилахад хүргэж буй цагдаагийн хүчний хүч хэрэглэх, доромжлон хандах зэрэг төрийн байгууллагын практик, хуулийн заалтыг устгах (Испани Улс)	ХЗЯ	Хэрэгжилтийн шатанд. Гэмт хэргийн тухай хуулийн шинэ төсөлд энэ талаар дараах байдлаар томъёолон тусгасан. Хуулийн төслийн 14.1-д Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол төрх байдал, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, эрүүл мэндийн нөхцөл байдлаар нь ялгаварлан гадуурхаж, эрх, эрх чөлөөг нь хязгаарласан, тодорхой үйлдэл, эс үйлдэхүй шаардсан, заналхийлсэн бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр тусгасан байна.
86.9. Эрүүгийн хууль тогтоомжид үзэн ядах гэмт хэргийг тодорхойлон оруулах замаар тийм гэмт хэргийн хохирогчдыг хамгаалах (Канад Улс)	ХЗЯ, УЕПГ	Хэрэгжилтийн шатанд. 86.8-ыг харна уу.
86.10. Цаазаар авах ялаар шийтгэгдсэн хүмүүсийн талаарх мэдээллийг ар гэрийнхэнд нь өгөх зорилгоор өнгөрсөн хугацаанд ногдуулсан цаазаар авах ялыг төрийн нууцад хамааруулсныг цуцлах (БНЧУ)	ҮАБЗ-ийн АА, УЕПГ, ХЗЯ	Хэрэгжилтийн шатанд. Төрийн нууцын тухай хууль, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах, Төрийн нууцын тухай хуульд өөрчлөлт оруулах, статистик мэдээлэл гаргах асуудлыг чиг үүргийнх нь дагуу ТЕГ-т тавьж шийдвэрлүүлэхээр ажиллаж байна.
86.11. Цаазаар авах ял ногдуулж, гүйцэтгэсэнтэй холбоотой мэдээллийг төрийн нууцын зэрэглэлд хамааруулах явдлыг арилгаж, цаазаар авах ял, түүний шийдвэр гүйцэтгэлтэй холбоотой мэдээлэл, статистик тоо баримтыг гаргах (Нидерланд Улс)	ҮАБЗ-ийн АА, УЕПГ, ХЗЯ	Хэрэгжилтийн шатанд. 86.11-ыг харна уу.